



# УУРХАЙН ХААЛТ

## ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Бодлогын судалгааны тайлан

Судалгааны баг: С. ЦЭДЭНДОРЖ  
Ж. БЯМБА-ЮУ  
М. ДАГВА

Улаанбаатар  
2010 он



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

## УУРХАЙН ХААЛТ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Судалгааны баг:

С. Цэдэндорж

Бодлогын судалгааны багийн ахлагч, Профессор, доктор Ph.D,

Ж. Бямба-Юу

Дэд профессор, доктор Ph.D

М. Дагва

ШУТИС-ийн багш, магистр

Энэхүү тайлангаар гаргасан үнэлэлт дүгнэлт нь уг тоймыг боловсруулсан судлаачдын байр суурийг илэрхийлнэ.

©Нээлттэй Нийгэм Форум

Зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно.

Энэхүү судалгааны тайланг хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж, хэвлэхийг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Хэвлэлийн хуудас 14.5  
Хэвлэсэн хувь 500  
DDC  
343.077  
У-594  
ISBN 978-99962-0-299-5

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

Монгол Улс,  
Улаанбаатар хот, 2010 он

## ГАРЧИГ

Товчилсон үгийн тайлбар	4
Удиртгал	5
Судалгааны зорилго	7
1. Уурхайн хаалтын онцлог, түүний эрх зүйн зохицуулалт	8
1.1. Уурхайн хаалт, түүний онцлог	8
1.2. Монгол улс дахь уурхайн хаалтын өнөөгийн байдал	9
1.3. Дэлхийн улс орнуудын явуулж буй жишиг бодлого, туршлага	13
1.4. Уурхайн хаалтын эрх зүйн хүрээ: Ямар асуудлуудыг зохицуулдаг вэ?	17
2. Монгол Улсын уурхайн хаалтын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал	21
3. Уурхайн хаалтын эрх зүйн шинэ орчин бий болгох арга замууд	32
4. Дүгнэлт	35
5. Зөвлөмж	37
Хавсралт 1. Монгол Улсын стандарт	
Уул уурхай. Уурхайн хаалт	
Нэр томъёо, тодорхойлолт	41
MNS..... : 2010	42
СХҮТ 2010	43
Хавсралт 2. Гүний тогтоцтой ордын ашиглалт, хаалтын үүд аюулгүй ба ашигтай орчин бүрдүүлэхэд баримтлах журамд тусгах заалтууд	48
Аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх баримтлал	49
Судалгааны арга зүй	56
Номзүй	58

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

АМГ	Ашигт малтмалын газар
АМТХууль	Ашигт малтмалын тухай хууль
БОНБНУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, Эрчим хүчний яам

## УДИРТГАЛ

Улсын мэргэжлийн хяналтын газар (УМХГ)-ын дэргэдэх Уул уурхайн мэргэжлийн хяналтын албаны гаргасан мэдээгээр “...өнөөдрийн байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглалт дуусаад орхигдсон уурхайн газар талбай 5000 гаруй га байна. Эдгээр газар талбайд нөхөн сэргээлтийн болон орчны аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлууд хариуцах эзэнгүй орхигдсон тул Мэргэжлийн хяналтын байгууллагаас эзэн холбогдогчийг тогтоох тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна...” Сүүлийн жилүүдэд голлон алтны шороон орд ашигласан уурхайнуудын ашиглалт дуусаж, нөхөн сэргээгдэхгүй орхигдож байснаас үүссэн сөрөг нөлөөлөл нь орон нутгийн малчид бэлчээргүй болох, гол горхи ширгэх, хүмүүс гэнэт олноор ажилгүй болох зэргээр илэрч байгаатай дээрх мэдээ холбогдох бөгөөд уг асуудлыг зохицуулах зорилгоор “...нөхөн сэргээлтийн стандартууд боловсруулж, хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр ажиллаж буй...” болохыг мөн дурьджээ.

Монгол Улсад сүүлийн 20-иод жилд уул уурхайн үйлдвэрлэлийн цар хүрээ эрчимтэй тэлж өсөн, олон арван уурхай шинээр нээгдэн ашиглалт явуулсан нь уул уурхайн мэргэжилтний баримжаагаар авч үзвэл голчлон “жижиг” уурхайнууд байж, газрын гадаргаас доош 50м орчим гүн малталтууд хийсэн. Бага гүнтэй уг малталтуудыг налуулах, дүүргэх боломж байх тул энэ чиглэлээр заавар журмууд гарч, холбогдох байгууллагуудаас шаардаж, компаниуд шаардлагын дагуу ажиллан эхний үр дүн гарч эхлэв. Бид уурхайн хаалтын асуудлыг шийдэх гарцаа олчих нь энэ үү? Хууль эрхзүй, журам заавар, стандартууд маань хангалттай, одоо зөвхөн уул уурхайн компаниудыг шахаад өгөхөд болоо юу?

Уул уурхайн салбарт Оюу толгой, Таван толгой зэрэг дэлхийн түвшиний томоохон бизнесийн төслүүд хэрэгжихтэй зэрэгцэн нүүрсний уурхай олноор нээгдэж эхэллээ. Алтны шороон ордуудаас ялгаатай нь эдгээр уурхай хамаагүй олон жил ашиглагдаж, 200 м ÷ 600 м магадгүй түүнээс ч илүү гүн ухаш үүсгэх бөгөөд дагалдах эерэг болон сөрөг нөлөөлөл нь бүс нутгийн болон улсын хэмжээнд мэдрэгдэх болно. Энэ жил

ухсан нүхээ дараа жил дахин гүнзгийрүүлээд явах тул бид жил жилдээ нөхөн сэргээлт хий гэж шаардаж чадахгүйд хүрч байна. Сүүлийн 10 гаруй жилд бий болгож, бага ч гэсэн үр дүнд хүргэсэн журам зааврууд маань шинэ нөхцөл байдлын өмнө дахин хүчин мөхөсдөж, та бид өөр цар хүрээ бүхий, өөр зохицуулалт шаардах уул уурхайн цаг үеийн өмнө зогсож байна. Уурхайн асуудлыг өөрчлөгдөж буй үйл ажиллагаа, түүнээс үүсэх нөлөөллийн өргөн хүрээнд авч үзэн **эрхзүйн иж бүрэн зохицуулалт** хийх цаг үе ирээд байна.

Улаан буудай тарих бизнесээ бид хүсвэл мянга мянган жилээр тухайн газарт үргэлжлүүлж болох байх. Харин харамсалтай нь уул уурхайг хаа нэгтээ эхлүүлж байгаа бол эрт орой нэгэн цагт газрын дорхи баялаг шавхагдах тул хаах, орхих нь зайлшгүй тодорхой байдаг. Уурхайг хаасны дараа улаанбуудай тарихыг хүсвэл эртнээс бодлогоо тодорхойлж эрхзүйн зохицуулалттай явах шаардлагатай.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

2008 оны дүн мэдээгээр Монгол Улсад ашигт малтмал хайх, олборлох 5,160 тусгай зөвшөөрөл олгогдоод байгаагийн 1,096 (408,407.2 га) нь ашиглалтын, 4,064 (47,600,537.8 га) нь хайгуулын тусгай зөвшөөрөл байна. Янз бүрийн эх сурвалжид Монгол орны нутаг дэвсгэрийн 30-60 хувьд нь ашиглалтын юмуу хайгуулын лиценз олгогдоод байгаа мэдээлэл дурьдагдсан байдаг. Эргэж сэргэхгүй байгалийн баялаг болох ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь эхлэл, төгсгөлтэй учир уул уурхайн хаалтын иж бүрэн зохицуулалтын механизмыг урьдчилан бий болгосон байх шаардлагатай гэж үзэж, уг зохицуулалтыг бий болгох, нэвтрүүлэх хэрэгцээ, боломж, арга замыг тодорхойлохыг судалгааны зорилго болгон дэвшүүлсэн юм.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг тавилаа. Үүнд:

- Уурхайн хаалтын асуудлыг зохицуулахтай холбоотой одоо үйлчилж байгаа хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх,
- Ашигт малтмал олборлох төслийн эхнээс дуусах хүртэл бүх хугацаанд уурхайн хаалтыг төлөвлөж, хэрэгжилтэнд нь хяналт тавих зарчмыг гаргаж ирэх, үүнийг дэлхийн бусад орны туршлагатай харьцуулан судлах,
- Уурхайн хаалтын эрх зүйн тогтолцоог Монгол Улсад бүрдүүлэх хэрэгцээ шаардлага, боломжид үнэлгээ дүгнэлт өгсний үндсэн дээр бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч талуудад хандсан бодлогын зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Энэ судалгаа нь уурхайг хаахтай холбоотой асуудлаар бодлого боловсруулахад чиглэсэн эхний оролдлого учраас цаашид технологи, экологи, эдийн засаг, эрх зүйн олон талт үзэгдэл, үйл явцыг нэгтгэсэн уурхайн хаалтын зохицуулалтыг судалгааны оновчтой арга зүйд тулгуурлан боловсруулах их ажил хийгдэх нь зайлшгүй юм.

## 1. УУРХАЙН ХААЛТЫН ОНЦЛОГ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 1.1. Уурхайн хаалт, түүний онцлог

Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагааны явцад газрын хэвлийд эвдрэл өөрчлөлт гарч, хүн ба амьтны амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэх, аюул осолтой, экологийн тэнцвэр алдагдсан орчин үүсэх хандлагатай байдаг. Мөн тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулсан уул уурхайн үйлдвэрийг дагаж барилга байгууламж баригдан, дэд бүтэц бий болж, орон нутгийн хүмүүсийн аж ахуй эрхлэн явуулах үйл ажиллагаа, амьдралын хэвшилд өөрчлөлт ордог тул уул уурхайн компанийн бизнес үйл ажиллагаа нь бүс нутгийн хөгжил, байгаль орчны хамгаалал, нийгмийн хамгаалал зэрэг олон ашиг сонирхлыг хөндөж байдаг.

Уул уурхайн үйлдвэрийг дагалдан тухайн байгаль орчин, нийгэмд бүрэлдэн бий болж буй эдгээр өөрчлөлтөөс уурхайг хаагдах үед эерэг үр дүнг нь хадгалан үлдэх, сөрөг үр дагаврыг арилгах, гэтлэн давахад чиглэсэн цогц арга ажиллагааг *уурхайн хаалт* гэнэ.

Ерөнхий байдлаар авч үзвэл уурхайн хаалтаар дараах асуудлыг шийдэх ёстой:

- Уурхай ашиглаж байгаад хааж орхисон газарт аюулгүй орчин бүрдүүлсэн байх;
- Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх;
- Нэгэнт бий болсон дэд бүтэц, барилга байгууламжийг цаашид аль болох үр ашигтай ашиглах;
- Уурхай хааснаас үүдэн гарах нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг багасгахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулсан байх;
- Хаасан уурхайн орчим ба түүний объектуудад урт хугацаанд мониторинг хийх, хяналт тавих.

Уурхай том, жижиг ямар ч хэмжээтэй байж болно. Гол нь тэр хэрээрээ тухайн орон нутагтаа, эсвэл улсынхаа нийгэм эдийн засагт тодорхой нөлөө үзүүлж ирсэн уг уурхайг тухайн орон нутаг, бүс нутаг, улс үндэстний эдийн



засаг, ард түмний ирээдүйд дарамт болгохгүйгээр хааж үлдээх нөхцөлийг хангах бодлого, зохицуулалт заавал байх ёстой юм. Энэ асуудлыг уурхайг хаахад ярьж эхлэх биш харин уурхайг нээх төлөвлөгөө боловсруулж байх үеэс л төлөвлөж, уурхайг ажиллаж байх нийт хугацаанд хэрэгжүүлж явах ёстой. Энэ зарчмыг хэрэгжүүлэхийн тулд тавигдах шаардлага, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал нь хууль эрхзүйн маш тодорхой зохицуулалттай байх учиртай.

## **1.2. Монгол Улс дахь уурхайн хаалтын өнөөгийн байдал**

Ерөө, Хараа, Бороо, Баруун ба Баруун хойд Хэнтийн алт бүхий бүс нутгуудад XIX зууны эхээр “Монголор” нийгэмлэгээс явуулж байсан уул уурхайн үйлдвэрлэл, түүнээс өмнөх үеийн гар олборлолтын баримт мэдээ олон байдаг боловч 1922 онд Налайхын нүүрсний уурхайг улсын мэдэлд авснаар Монголын уул уурхайн салбарын шинэхэн үеийн түүх эхэлжээ. 90 шахам жилийн түүхэнд хаагдсан болон орхигдсон уурхайнууд цөөнгүй бий. Уг түүхийг эхлүүлж буй Налайхын уурхайд 1989 онд шатамхай хийн тэсрэлт болж, олон хүний амь эрсдэн, уурхайн малталтууд эвдрэлд орсноор хаагдсан. Үүний улмаас Налайх сууринд өнөөдөр ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн хүндрэлтэй асуудлууд ихээр хуримтлагдсан нь уурхайн хаалтыг төлөвлөөгүй, энэ талаар ямар ч төсөөлөлгүйгээр үйлдвэрлэл явуулж ирсэнтэй холбоотой.

1960-аад оноос эхлэн ашигласан Шарын голын нүүрсний уурхайд нөөцийг нь бүрэн ашиглаж чадалгүй уурхайг хаах хүртэл нөхцөл байдал тулгараад байгаа бөгөөд уурхай хаагдсан тохиолдолд Шарын гол суурингийн хүн амын амьжиргааны үндсэн эх үүсвэрийг хангаж, ажилгүйдэл, ядуурлаас сэргийлэхээс гадна хотхон, төмөр зам, уурхайн засвар, үйлчилгээний байгууламжууд, цахилгааны сүлжээ болон бусад дэд бүтцийг үр ашигтай ашиглахад чиглэсэн шийдлүүдийг гаргаж ирэх хэрэгцээ тулгарч байна. Мөн тус уурхайг төр ашиглах явцдаа хаалтын зардалд зориулан сан бүрдүүлээгүй, уурхайн талбайг хэрхэн буцаан нөхөн сэргээх талаар төлөвлөлт хийгээгүй бөгөөд сүүлд худалдан авсан компани нь өөрийн хөрөнгөөр уг ажлыг гүйцэтгэх чадамжгүй байгаа юм.

1990-ээд онд хэрэгжсэн “Алт хөтөлбөр”-ийн хүрээнд алтны шороон орд ашиглахыг идэвхитэй дэмжсэн бөгөөд өнөөдрийн байдлаар ихэнх шороон ордуудад ашиглалт дууссан боловч хаалт, нөхөн сэргээлтийг системтэй хийгээгүйгээс алтны бүс нутгуудад олон асуудал үүсэж байна. Энд гол усны бохирдол, газрын гадаргын эвдрэл, тоос шороо, бэлчээрийн доройтол зэрэг байгаль орчны холбогдолтой асуудлаас гадна гар аргаар алт олборлогчид олноор төвлөрснөөс газрын эвдрэл улам даамжрахаас авахуулаад нийгмийн хэв журам болон хүний эрхийн зөрчил зэрэг нийгмийн чанартай олон сөрөг үр дагавар хуримтлагдаж үлдсэн байна.

Шороон орд ашигладаг алтны уурхайнууд нь голлон 10-20 м, ихдээ 40-50 м гүнд ашиглалт явуулдаг бөгөөд уурхайн талбай нь сунаж тогтсон байдаг тул эхний жил ашигласан талбайг дараа жил нь нөхөн сэргээх боломжтой байдаг. Одоогийн уурхайн хаалтын эрх зүйн орчин нь зонхилох байдлаар гадаргын тогтоцтой шороон ордын нутаг дэвсгэрт хийх нөхөн сэргээлт, хаалтын үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн журам, заавраас бүрдэж<sup>1</sup> байна.

Голдуу дотоодын уул уурхайн компаниудын хэрэгжүүлсэн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хаалтын бодлого, төлөвлөгөө, зохицуулалт байхгүй байсны улмаас дараах үр дагавар гарч байна:

- а) *Байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл*
- Эргэж сэргэх боломжгүй байгалийн үнэт баялгийг гүйцэд ашиглалгүй орхисноос тухайн үлдэж буй баялаг цаашид ашиглагдах боломжгүйгээр хаягдаж байна. Заамарт ажилласан зарим уурхайн баяжуулах төхөөрөмж металлын 90-ээс дээш хувийг авахаар төлөвлөж байсан ч бодит байдал дээр 50 орчим хувийг авч байсан тухай яригддаг.
  - Газрын гадарга, хэвлийд нүх, ухаш, овоолго үүсгэснээс болж гадаргын төрх байдал дордов. Туул гол дагуух хайрганы орхигдсон уурхайнууд үүний жишээ болно.


<sup>1</sup> Ашигт малтмалын тухай хууль. 30-40, 45-р зүйл

- Агаар, хөрс, гадаргын болон гүний ус бохирдож экологийн доройтол үүслээ. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт энэ жишээ маш тод харагдаж байна.
  - Ургамлын төрөл зүйл өөрчлөгдөх, амьтад дайжих, устаж үгүй болох үр дагавар үүсэж байна. Харамсалтай нь суурь судалгаа, явцын мониторингийн мэдээлэл байхгүй учраас энэ талаар иш татах бэлэн жишээ байхгүй байна.
  - Уул уурхайн ашиглалт дууссаны дараагаар уг үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл нь их бага хэмжээгээр олон жилийн турш үргэлжилж байдаг ч энэ талаар ямар нэг үнэлгээ, мониторинг хийгдэхгүй байна.
- б) *Бүс нутгийн болон орон нутгийн нийгэм эдийн засагт тусах нөлөө*
- Уул уурхайн төсөл хэрэгжих явцад тухайн орон нутгийн эдийн засаг уг төслөөс тодорхой хэмжээгээр хараат болж байна.
  - Нутгийн оршин суугчдын амьдралын хэвшил, ажил эрхлэлтийн бүтэц өөрчлөгдөж байна. Хөдөлмөрийн насны нийт хүн амын 30 түүнээс ч илүү хувь нь уурхайд ажиллах, уурхайд ажил үйлчилгээ нийлүүлэх зэргээр орон нутгийнхаа нэг уурхайтай холбоотой ямар нэг бизнесийг эрхэлдэг сумууд бий болж эхэллээ. Цаашдаа иймэрхүү бүтэцтэй аймаг ч бий болж магадгүй байна.
  - Уул уурхайн компани дампуурах тохиолдолд орон нутгийн хувьд төлөвлөгдөөгүй олон сөрөг асуудлууд хуримтлагдаж үлддэг.
  - Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар уул уурхайд ажиллаж байсан хүмүүсийн ажил эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхгүй орхивол ядуурал, ажилгүйдэл нэмэгдэнэ. Налайхын уурхай гэнэт хаагдсаны дараа нийтийг хамарсан ажилгүйдэл үүссэн, улмаар иргэд амь насаа алдах эрсдэл бүхий гар аргаар нүүрс олборлох үйл ажиллагаа эрхлэх болсон зэрэг нийгэм, эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл өнөөдөр ч үргэлжилсээр байна.
  - Төслийг дэмжиж байгуулагдсан дэд бүтцийг цаашид орон нутаг ашиглахад арчилгаа, зардлыг нь дийлэхгүй

байхаас үүдэлтэй орон нутагт дарамт үүсэх асуудал гарч байгааг Өргөний уурхайн тосгоны жишээ харуулж байна.


Дээрх цөөн хэдэн жишээнээс харахад уурхайн хаалт нь эрх зүйн нарийн зохицуулалт, төслийг хэрэгжүүлэгч, хянагч болон бусад бүх оролцогч талаас ихээхэн хүчин чармайлт шаардсан, анхнаас нь төлөвлөж, төсөвлөж байх шаардлагатай байна.

Эрдэс баялаг, Эрчим хүчний яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ) нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашигт малтмал ашиглах төслүүдийг хүлээн авч хэлэлцэн, хуулийн этгээдэд уул уурхайн үйл ажиллагаа явуулах ашиглалтын тусгай зөвшөөрөл олгодог. ЭБМЗ дээр цугласан Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-үүд нь судалгааны өгөгдлийн санд орж, одоо мэдээллийн бааз болж бүрдээд байна. Ашигт малтмалын газар (АМГ)-т сүүлийн гурван жилийн хугацаанд хүлээн авсан, үйл ажиллагаа нь эхэлсэн буюу эхлэх шатандаа явж буй ТЭЗҮ-үүдийг судалж үзэхэд нийт 39 орд дээр (Зураг 1.) алт, нүүрс, төмрийн хүдэр, барилгын материал, жонш болон бусад ашигт малтмалыг олборлох уурхай байгуулахаар төлөвлөгдсөн байна.



Зураг 1. АМГ-т бүртгэлтэй ТЭЗҮ дэх ашиглалтын хугацаа

Төслүүдийг төрлөөр нь авч үзвэл ойрын таван жилд алт, жоншны уурхайн хаалт зонхилох бол 6-20 жилийн буюу дунд хугацаанд төмрийн хүдэр, нүүрсний уурхайн (Зураг 2.) хаалтын асуудал түлхүү тавигдахаар байна.



Зураг 2. Хаагдах уурхайнууд ашигт малтмалын төрлөөр

Одоогийн байдлаар хүдрийн уурхайнууд нь дунджаар 50-250 м гүнд, ихдээ 300-600 м хүртэл гүнд ашиглалт явуулж байна. Хаалт, нөхөн сэргээлтийн гол ажлууд хүдрийн ордыг бүрэн ашиглаж дуусах сүүлийн үе шатанд болон дууссан хойно нь хийгддэг онцлогтой. Тиймээс шороон ордыг ашиглаж, хааж ирсэн байдлаас эрс ялгаатай нөхцөл бидний өмнө тулгарах нь ээ.


Иймд уурхайн хаалтын эрх зүйн зохицуулалт нь зөвхөн өнөөдрийн тулгарч буй хүндрэлтэй асуудлуудын хүрээнд бус ирээдүйд хаагдах уурхайн онцлогийг тусгасан байх шаардлагатай болж байна.

Бид энэхүү бодлогын судалгаандаа уурхайн хаалттай холбоотой эрх зүйн зохицуулалтыг дээрх асуудлуудад чиглүүлэх зорилго, зорилтуудыг тавьсан.

### 1.3. Дэлхийн улс орнуудын явуулж буй жишиг бодлого, туршлага

Дэлхийн уул уурхайн практикт тухайн ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах шатнаас эхлэн уурхайн хаалтын асуудлыг төлөвлөх, шийдвэрлэх нь зүйтэй гэсэн нэгдсэн ойлголт нэгэнт тогтож хэвшиж байна. 2008 оноос эхэлсэн Дэлхийн эдийн засгийн хямралын улмаас гэнэт үйл ажиллагаагаа зогсоосон олон уурхайн (Зураг 3.) хаалтын асуудал гарч ирсэн нь уурхайн хаалт төлөвлөж байснаас эрт хийгдэх эрсдэл

байдаг бөгөөд үүнд бэлэн байж, уг тогтолцоог цаашид улам төгөлдөршүүлэх нь чухал гэдгийг нотлон санууллаа.




Зураг 3. 2008/2009 онд төвлөсөн хугацаанаас өмнө хаагдсан уурхайнууд (Д.Лауренс)

Тогтоогдсон нөөцийг ашиглаж дуусаад төслөөр анх төлөвлөсөн хугацаанд уурхайг хаах ёстой, улмаар хаалтын асуудлыг тэр үед хэрэгжүүлэх учраас хаалтад зарцуулах санхүүжилтийг ашиглалтын сүүлийн жилүүдэд шийдвэрлэх боломжтой гэсэн ойлголт түгээмэл байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд хаагдсан нийт уурхайн  $\frac{1}{4}$  нь л нөөц шавхагдсаны улмаас буюу анхны төлөвлөсөн байдлаар, бусад нь өөр шалтгаанаар (Зураг 4.) хаагдсаныг судлаач Д.Лауренс<sup>2</sup> бүртгэсэн байна.

Лауренс докторын судалгааны ажил бидний уламжлалт ойлголт буруу болохыг харуулахын дээр төлөвлөгдөөгүй хаалтын талаар эрхзүйн зохицуулалт байх ёстойг сануулж байна.

Эрхзүйн хувьд анхаарах өөр нэг асуудал нь хаалтын үйл ажиллагааны санхүүжилт байдаг. Туршлагаас үзэхэд баруун Австрали зэрэг уул уурхай түлхүү хөгжсөн газруудад хаалт, нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийг бондын механизм ашиглан бүрдүүлэх замаар уурхайн хаалтын үед гарах санхүүгийн эрсдэлүүдийг багасгадаг бөгөөд үүнд уурхайн

<sup>2</sup> Д. Лауренс – Австралийн Шинэ Өмнөд Уэлсийн Их сургуулийн профессор. “Уурхай яагаад хаагддаг вэ?” өгүүлэлийн зохиогч.



Зураг 4. Уурхайн хаагдахад нөлөөлсөн голлох шалтгаанууд (Д. Лауренс)

талбай дахь байгууламжуудыг буулгаж зайлуулах, талбайг засаж хэлбэржүүлэн ургамалжуулах зэрэг хаалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажил болон уг арга хэмжээний үр дүнг 5-10 жилийн хугацаанд хянаж байх мониторингийн холбогдолтой ажлыг оруулдаг байна. Бонд ашиглан хөрөнгө дайчлах ажлын шударга байдлыг хангах үүднээс ашиглалтад өртөж буй эдэлбэрийн хүрээний газрыг дотор нь ангилж тэдгээрт ноогдох бондын үнэлгээг ялгавартай тогтоон хуульчилдаг туршлагыг Австрали, Канад болон бусад орны жишээнээс харж болно. Үүнд:

1. Уурхайн туслах байгууламжууд, зам харилцаа, дэд бүтцийн зориулалтын газар талбайн үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байх тул нэгжийн үнэлгээ нь бага байна.
2. Уурхай болон овоолгод эзлэгдэх газар дунд зэргийн эвдрэлд орох тул нэгжийн үнэлгээ нь дундаж байна.
3. Цианид, хүхрийн хүчил зэрэг хортой бодисоор уусгалт явуулсан овоолго, баяжуулах үйлдвэрийн хаядасны хураагуур байршуулсан талбайд аюултай болон хортой нөлөөлөл үүсгэж болзошгүй тул уг газарт нэгжийн үнэлгээг өндөр тогтооно.

Мөн хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын санхүүгийн тайлан гаргах зааварт жил бүрийн тайландаа уурхайн үйл ажиллагааг хаахтай холбоотой хүлээсэн үүргийн

дагуу зарцуулахаар хуримтлуулж буй сангийн мөнгөн дүнг тайлагнахыг журамласан<sup>3</sup> байна.

Уул уурхайн компаниудын хувьд уурхайн хаалтын төлөвлөгөөнд тусгагдаж, бондоор барьцаалагдсан үйл ажиллагаануудыг гүйцэтгэхээс гадна бусад эрсдэлийг хаахад чиглэн дараах арга буюу хувилбарыг баримталдаг туршлага байна. Үүнд:

- Лицензээ улсад буцааж өгөлгүй өөртөө хадгалж байх бөгөөд ирээдүйд гарах зардал, эрсдэлийг хаах зориулалт бүхий компанийн дотоод хуримтлал үүсгэнэ. Тухайн хувилбар нь ихээхэн эрсдэл бүхий буюу аюултай, хортой нөлөөлөл үүсгэж болох уурхай ба түүний зарим объектод хамаатай.
- Ашиглалтын лицензээ улсад буцааж өгөх бөгөөд дагалдуулан хаалтын дараах зардал болон үлдэгдэл эрсдэлийг хаах төлбөр төлнө. Эрсдэл багатай уурхай ба түүний объектод энэхүү хувилбар тохиромжтой.
- Тухайн газрын эзэмшлийг тусгай зориулалт чиглэлээр ажилладаг компанид шилжүүлэхдээ талбайтай холбоотой үлдэгдэл үүрэг хариуцлагыг мөн шилжүүлэх ба даатгалжуулна.

Уурхайн хаалт ба түүний хүрээнд явуулах нөхөн сэргээлтийн ажлаар мэргэшсэн компани, эсвэл уг уурхайн объектуудыг хүлээн авч цаашид аж ахуйн эргэлтэнд оруулах сонирхол бүхий компани уг үүрэг хариуцлагыг шилжүүлэн авдаг практик байна.

- Хаалт хийгдсэн талбайг ирээдүйд харж хандах, арчлах, болзошгүй эрсдэлүүдийг нь хариуцах нөхцөлтэйгээр өөрийн өмч, эзэмшлийн зарим хэсгээ орон нутагт буюу улсад шилжүүлнэ.

Харьцангуй эрсдэл багатай уурхай ба объектын хувьд тухайн хувилбар тохиромжтой.

Монгол Улс нэгэнт бий болсон дээрх загвар, шийдлүүдийг анхааралтай судалж, өөрийн орны эрх зүйн орчинг уурхайн өвөрмөц онцлогт тохируулах чиглэлээр нарийвчлан боловсруулахад ашиглах шаардлагатай байна. Гадны улс орнууд

<sup>3</sup> Asset Retirement Obligation, Canada or FAS 143, USA.



уурхайг нээхээс өмнө тухайн уурхайн ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг урьдчилан тооцоолсны үндсэн дээр уурхайн хаалтын үйл ажиллагаа, тэдгээрийн санхүүжилтэд анхаарсан эрх зүйн орчин бий болгон хэрэгжүүлж байна. Мөн гадаад орны туршлагаас уурхай хаагдах ялгаатай нөхцөлд, хаалттай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжүүлэх хөрөнгө нөөц нь бэлэн байх ёстойг бид олж харсан бөгөөд үүнийг ч эрх зүйн орчиндоо тусгах ёстой. Эдгээрээс харахад, уурхайн хаалтын эрх зүйн орчин нь уурхайн үйл ажиллагааны ялгаатай төрөл хэлбэрт тохирсон байхаас гадна уурхай хаагдах янз бүрийн нөхцөлд бэлэн байх зарчимд нийцсэн байх ёстой юм.

#### **1.4. Уурхайн хаалтын эрх зүйн хүрээ: Ямар асуудлуудыг зохицуулдаг вэ?**

Монгол Улс уурхайн хаалтын эрхзүйн орчинг ирээдүйд ямар түвшинд хүргэх зорилтыг баримжаалах үүднээс гадны улсуудын эрхзүйн орчинг харьцуулан судалж тойм хүрээг гаргалаа. Бодлогын тодорхой шийдэл (олон улсын хэмжээнд баримтлах зарчим, эсвэл тодорхой нэг улсын эрх зүйн орчин) бүр нь тухайн орчин, орны онцлогт нийцсэн нарийвчилсан зохицуулалтуудыг агуулж байгаа нь тодорхой ч мөн үүний зэрэгцээ уурхайн үйл ажиллагаа явуулах, түүнийг дуусгавар болгохтой холбоотой нийгэм, байгаль орчны хувьд анхаарах нийтлэг асуудлуудыг мөн хамарсан байгаа. Тиймээс маш санамсаргүй байдлаар (интернетээр олдсон судалгааны материалын хүрээнд) сонгож авсан доорх хэдэн жишээ ч гэсэн Монголд уурхайн хаалтын эрх зүйн орчинг бэхжүүлэхэд санаа авах мэдээллийн эх сурвалж болно хэмээн найдаж байна.

*Олон улсын хэмжээнд баримталж буй зарчим, шалгуур*

Олон улсын түвшинд уурхайн хаалтын зохицуулалт, хяналтын асуудлыг эрхлэн ажилладаг байгууллага байхгүй ч дэлхийн болон олон улсын санхүүгийн байгууллагууд энэ чиглэлээр санаачилга гарган идэвхитэй ажиллаж байна. Энэ нь нийгмийн хариуцлага бөгөөд аюул эрсдэл багатай санхүү, банкны үйл ажиллагааг эрхлэн явуулахтай холбоотой чухал асуудал тул олон улсын банкууд үүнд

анхаарал хандуулж байна. Жишээлбэл, Дэлхийн Банк *Equator Principles* хэмээх зарчмуудыг боловсруулсан, зээлдэгч орнуудын банк, санхүүгийн байгууллагууд нь нийгмийн болон байгаль орчны эрсдэлийг үнэлсний дараа төслийн санхүүжилт хийж байх шаардлага юм. Олон улсын санхүүгийн корпорациас төслийг байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллөөр нь А (хүчтэй бөгөөд засаж залруулах боломжгүй сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай), В (хариу арга хэмжээгээр засаж залруулж болох зарим сөрөг нөлөөлтэй), С (сөрөг нөлөөлөл маш бага юмуу бараг үгүй) гэсэн ангилалд хуваадаг байна.

*Үндэсний хэмжээнд мөрдөж буй журам*

**Өмнөд Америк.** Өмнөд Америкийн Аргентин, Боливи, Колумби, Эквадор, Бразил, Чили, Перу улсуудад уурхай эрхэлж байсан газар нутгийг нөхөн сэргээх асуудлаар эрх зүйн зохицуулалт батлан мөрдүүлж байна.

**Чилийн** уул уурхайн хуулиудад уурхайн хаалтад тавих шаардлагууд, мөн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах талаар ерөнхий удирдамж багтсан байна. Хэдэн жилийн өмнө "Уурхайн хаалтын тухай хууль"-ийн төсөл боловсруулагдсан ч өнөөг хүртэл батлагдаагүй байгаа бөгөөд энэ хуулийн төсөлд уурхайг хаах техникийн төсөл, олон нийтэд нээлттэй зарлах мэдээлэл, санхүүгийн баталгаа зэрэг асуудлыг тусгасан байх ёстой. Гэтэл Перугийн хуулиар уул уурхайн компани нь газрыг нөхөн сэргээх арга хэлбэр, хаалтын үйл ажиллагааны төсвийн төсөөлөл, хяналт болон баталгаажуулах үйл явц, хаалтын болон хаалтын дараах үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн баталгаа зэргийг нарийвчлан заасан төлөвлөгөө гаргаж өгөх шаардлага хэвшсэн байна. 2006 онд Эрдэс баялаг, уул уурхайн яам нь уул уурхай эрхлэгч компаниудад тусламж болгож уурхай хаалтын төлөвлөгөө боловсруулах арга зүйн гарын авлага хэвлүүлж тараажээ.

**Хойд Америк.** Канад, Мексик, АНУ нь уурхайг хаах зохицуулалттай улсуудын тоонд орно. АНУ, Канадад тусгайлсан хууль байхгүй ч хэд хэдэн хуулийн зүйл, заалтуудаар уурхайн хаалтыг нэлээд нарийн зохицуулж өгсөн

байдаг. Хэдийгээр эрх зүйн хүрээ нь олон хуулийг багтаасан ээдрээтэй бүтэцтэй мэт харагдаж байгаа ч хэрэгжилтэд хяналт тавих хүчтэй тогтолцоо, өндөр барьцаа зэрэг нь хэрэгжилтийг зайлшгүй шинжтэй болгож чаддаг. Мексик Улс уурхайн газрыг нөхөн сэргээх тухай тусгайлсан хууль байхгүй ч байгаль орчны багц хуулийн зүйл заалтуудаар нарийн зохицуулж өгсний дээр уурхайг хаахад тавигдах шаардлагуудаа боловсруулж байгаа юм байна.

АНУ-д уурхайн хаалтын асуудлаар Холбооны улсын түвшинд хүрээлэн буй орчны хэд хэдэн хуулиуд, муж улс, орон нутгийн түвшинд мөн журмуудаар зохицуулж байдаг. Ихэнх мужуудад тусгайлсан хуулиуд, техникийн шаардлага бүхий журмууд, зааварчилгууд мөрдөгдөж байна. Жишээлэхэд, Аризонад хаалтын асуудал хариуцсан хоёр агентлаг байгаа нь Аризонагийн Хүрээлэн буй орчны чанарын хэлтэс (ADEQ) ба Мужийн Уул уурхайн Хяналтын Оффис хэмээх байгууллагууд болно. ADEQ нь хүрээлэн буй орчинд үзүүлэх ерөнхий нөлөөлөлтэй (хөрс, ус, агаар) холбоотой асуудлыг хариуцаж байхад Уул уурхайн хяналтын оффис нь тухайн уурхайн аюулгүй байдлыг (хаалт хийгдсэн хаягдлын далангийн тогтворжилт, далд уурхайн малталтын аюулгүй байдал г.м) хариуцаж байна. Уурхайн үйл ажиллагааны явцад болон төлөвлөж төсөөлж буй хаалтын дараах нөхцөл байдлын нарийвчилсан үнэлгээ хийсний үндсэн дээр хаалтын зөвшөөрөл олгогддог.

Хаалтын төлөвлөгөө дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байдаг. Үүнд:

- Орд газрын тухай мэдээлэл (газрын гадарга, лицензийн хил, байгууламжууд г.м);
- Хаалт хийх процедурыг заасан тодорхойлолт, мөн хаалтын өөр бусад хувилбаруудад өгсөн судалгаа дүгнэлт;
- Тухайн газрын болон бүс нутгийн ус зүй, геологийн тогтоц;
- Барилга, байгууламж тус бүрийг хаах нарийвчилсан арга ажиллагаа;
- Хаалтын дараа үргэлжлүүлэн нөлөөлөл өгөх

байгууламжуудаас гүний усанд үзүүлэх нөлөөлөл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй болохыг нотолсон загварчлал тооцоо;

- Компани хаалтыг зохих ёсоор хийж чадахыг баталсан санхүүгийн баталгаа;
- Компани болон түүний туслан гүйцэтгэгч нь хаалтыг иж бүрэн хийх техникийн чадамжтайг харуулах зэрэг болно.

Хаалтын дараах нөхцөл байдал, урт хугацааны хяналт мониторингийн төлөвлөгөөнд үндэслэн хаалтын зөвшөөрлийг олгодог. Үүнд:

- Цаашид үлдэж хоцрох байгууламжуудад хаалт хийгдсэн байдал (уусгалт хийгдсэн овоолго, хаягдлын далан г.м);
- Хаалтын дараах хөрсний нөхцөл байдлын үнэлгээ;
- Хаалт хийгдсэн байгууламжуудад хийгдэх үзлэг; шалгалт, гүний усны чанарын хяналт, мониторингийн төлөвлөгөө;
- Зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан бохирдол гарах, гүний усны чанар муудах, хаалт хийгдсэн байгууламжууд эвдрэх зэрэг тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө;
- Бүртгэл, тайлагналын төлөвлөлт;
- Гүний усны моделийг ирээдүйд шинэчилж байх асуудал зэрэг багтана.

## 2. МОНГОЛ УЛСЫН УУРХАЙН ХААЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өмнөговь аймгийн нутаг дахь Нарийнсухайтын ордод өнөөдөр гурван компани нүүрс олборлож байна. Эдгээр уурхайд ашиглалт эхлэхийн өмнө тус бүрд нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ) хийсэн байна. Уурхай бүрт өөр өөр үнэлгээний компани ажилласан бөгөөд тухайлбал, уурхайгаас улсын хил хүртэл нүүрс тээвэрлэх автомашинуудаас гарах тоосны нөлөөллийг уурхай бүрээр салангид тооцсон. Уг гурван уурхай зэрэг ажиллах үед бий болсон замын тоосны нийлбэр нөлөөлөл нь тухайн орчиндоо гамшгийн хэмжээнд хүрч, ноцтой асуудал үүсэж байсныг бид маш сайн санаж байна.

Ашиглалтад өртөж буй орд болгонд хаалтын цогц асуудал тулгарна. Чиг баримтлал, хэрэгжүүлэх цаг хугацаа, орон зай, хөрөнгө хүч, хүрэх үр дүн талаасаа уурхай бүрийн хаалт давтагдашгүй шинжтэй байна. Иймээс уурхайн хаалтын бодлогыг төслийн хүрээнд бүх талаас нь сайн бодож боловсруулах шаардлагатай. Техник, технологийн талаас хаалтын холбогдолтой бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх төслийн шийдлүүдийг бодож, томъёолж болохыг амьдрал, практик харуулж байна. Харин нутгийн онцлог, уурхайн өвөрмөц шинжийг харгалзсан салангид шийдлүүдийг нэгдсэн төлөвлөгөө болгож боловсруулах, улмаар түүнийгээ хэрэгжүүлэх хариуцлагыг шаардах суурь дэвсгэр нь уурхайн хаалтыг зохицуулсан эрх зүйн орчин байх юм.

Өнөөгийн уул уурхайн практикт уурхайн хаалтын асуудлыг иж бүрэн тодорхойлж шийдвэрлэхийн тулд хамгийн багадаа 30 орчим асуудлыг авч үзэж байгаагийн 10 нь эрхзүйн актуудаар зохицуулах шаардлагатай байна. Компаний түвшинд судалсан асуудал бүс нутгийн хэмжээний шийдэлгүйгээр оновчтой болж чаддаггүйг харуулсан Нарийнсухайт дахь жишээнээс үүдэн Монгол Улсын хууль эрхзүйн актуудын хоорондын уялдаа холбоо болон уурхайн хаалттай холбоотой суурь 10 асуудлыг хэрхэн зохицуулж буй байдалд шинжилгээ хийв. Уг шинжилгээнд Монгол Улсын тодорхой хуулийн зүйл заалт нь уурхайн хаалтын ямар асуудлыг зохицуулж байгааг харуулаад, өөрсдийн

хийсэн дүн шинжилгээний дүнгээр тухай хуулийн хүрээнд зохицуулалтгүй үлдсэн асуудлуудыг хүснэгтээр харууллаа.

### 1. Хаалтын асуудлыг зохицуулсан үндсэн акт

Эрхзүйн актын нэр	Заалт	Анхаарах асуудал
<b>Газрын хэвлийн тухай хууль</b> Өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулах зорилттой хууль	20 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх үүрэг. 20.2.4 Газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, улс ардын аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан анх зөвшөөрөл олгосон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх	Хуулийн 7 дугаар бүлэгт газрын хэвлийг хамгаалах талаар заасан. Уг бүлэгт болон хуулинд нийтэд нь уурхайн хаалтын үеийн ба хаалтын дараах арга хэмжээ, хяналтын талаар үндсэн заалт суулгаж өгөх шаардлагатай.
<b>АМТХууль.</b> Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хаах бол нэг жилээс доошгүй хугацааны өмнө мэргэжлийн хяналтын албанд энэ тухай албан бичгээр мэдэгдэх бөгөөд уг албаны гаргасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж заажээ.	Уурхайн хаалтын нийгэм, эдийн засаг, байгаль орчны олон талт асуудлыг цогцоор авч үзсэн зохицуулалт болж чадахгүй. Ашиглалт явагдсаны дараах тодорхой хугацааг мөн хуулиар зохицуулдаг болох шаардлагатай.
<b>Газрын тухай хууль.</b> Газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулна.	Газрыг үр ашигтай зохистой ашиглах, хамгаалах Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна гэж заагдсан.	Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл нь уурхайн хаалтын төсөл, хаалтын дараах мониторингийн төслийг бүрэн төлөөлж чадахгүй. Хаалтын төслийн талаар зааж өгөх шаардлагатай.

<p><b>Уурхайг түр болон бүрмөсөн хаах журам.</b> Түр болон бүрмөсөн хаах уурхай, уулын малталтын бүс дотор хүн аюулгүй байх, ажил гүйцэтгэх нөхцөлийг хангуулж, уурхайн эдэлбэрийн доторхи ашигт малтмалын хайгдсан нөөцийг иж бүрэн, эдийн засгийн хувьд ашигтай, аюул осолгүйгээр ашиглана.</p>	<p>Уурхайн уул-геологи, гидрогеологи, техник эдийн засгийн нөхцөл зэрэг гол үзүүлэлтүүдэд өөрчлөлт гарсан бол түр хааж, харин уурхайн эдэлбэр газрын хилийн доторхи ашигт малтмалын тогтоосон нөөцөөс олборлон улсын эрдсийн баялгийн нөөцийн бүртгэлээс хасаж, нөөцийг өсгөх ирээдүйгүй гэж үзвэл уурхайг бүр мөсөн хаана гэж заасан.</p>	<p>Уурхайг хаахтай холбоотой техник ажил, процедурт анхаарсан, лиценз эзэмшигчид хандсан тул бусад оролцогчдын асуудлыг орхигдуулсан. Түр хаалтын үргэлжлэх хугацаа, тухайн хугацаан дахь лиценз эзэмшигчийн үүрэг хариуцлагыг тодруулж журамлах шаардлагатай. Хаалтыг илүү өргөн утгаар харсан хэд хэдэн журам шаардлагатай.</p>
<p><b>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль.</b> Байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцэл алдагдахаас сэргийлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах, төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулна.</p>	<p>Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон бусад хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх бөгөөд энэхүү үнэлгээний хүрээнд төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоож дүгнэлт гаргана гэж заасан.</p>	

## 2. Ашигт малтмалын нөөцийн иж бүрэн ашиглалт

Эрхзүйн актын нэр	Заалт	Анхаарах асуудал
<b>Газрын хэвлийн тухай хууль.</b> Өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулна.	Үндсэн болон түүнтэй хамт орших дагалдах ашигт малтмалыг иж бүрэн, бүрэн гүйцэд ашиглах мөн ашигт малтмалын нөөцийг ашиглахад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс газрын хэвлийг хамгаалах гэж заасан.	Нөөцийг бүрэн гүйцэд ашиглах үзэл баримтлал энэ хуулинд суусан бөгөөд АМТХ-д үүнийг дэлгэрүүлэн нарийвчилж зохицуулсан заалтууд байхгүй. Хуулиуд хоорондын уялдааг сайжруулах шаардлагатай.

## 3. Байгаль орчны асуудал

Эрхзүйн актын нэр	Заалт	Анхаарах асуудал
<b>АМТХууль.</b>	Хуулийн 37-45-р зүйлүүдэд байгаль орчны хамгаалал, хаалтын асуудлаар заалтууд орсон.	

## 4. Ашигт малтмал ашиглах зөвшөөрөл олгох шатанд хаалтын асуудлыг зохицуулж байгаа эсэх

Эрхзүйн актын нэр	Заалт	Анхаарах асуудал
<b>АМТХууль.</b>	Хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэх	Уурхайн хаалтын төлөвлөгөөг ерөнхий байдлаар хийгээд цаашид улам бүр нарийвчилж явах зарчмыг нэмж оруулах шаардлагатай.



5. Хаалтын холбогдолтой нийгмийн асуудлуудыг эрхзүйн актаар зохируулж байгаа эсэх

Эрхзүйн актын нэр	Заалт	Анхаарах асуудал
АМТХууль.	Эдийн засаг нийгмийн бүх хүрээнд байгалийн хүчин зүйл болон хүний үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөлд геоэкологийн судалгаа хийж үнэлгээ өгөх мөн уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах гэж заасан.	Ашиглалтын лиценз олгох, ашиглалт явуулах, хаалт хийх, хаалтын дараах шат бүрээр нийгмийн асуудлыг тусгайлан авч үзэж төлөвлөлтөд тусгах шаардлагыг нэмж оруулах.

6. Хаалт хийгдсэн уурхайн талбай, эдэлбэр газрыг улсад буцаан хүлээлгэн өгөх асуудал

Эрхзүйн актын нэр	Заалт	Анхаарах асуудал
АМТХууль.	Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас үүсч бий болсон, аюул учруулж болзошгүй газруудыг зохих масштабын газрын зураг дээр нарийвчлан тэмдэглэж, шаардлагатай тэмдэг, дохио, сануулгыг уурхайн эдэлбэрийн орчинд байрлуулах бөгөөд газрын зургийг мэргэжлийн хяналтын алба болон тухайн сум, баг, дүүргийн засаг даргад хүлээлгэн өгнө гэж заасан.	Уурхайн хаалт хийсэн талбайг буцааж хүлээн авах олон талт шалгуурын зарчим бий болгох, төрийн шат шатны байгууллагын оролцоог илүү тодотгох шаардлагатай.

Үлдэж буй 5 асуудалд ямар нэгэн эрхзүйн зохицуулалт байхгүй байгаа бөгөөд эдгээр нь:

- Уурхайн хаалтын барьцаа хөрөнгө бүрдүүлэх, хадгалах, зарцуулах, буцаан олгох;

- Хаалт хийгдсэн талбай дахь хаалтын дараах хяналт, мониторинги;
- Орд/Уурхайн эзэмшигч хуулийн этгээд өөрчлөгдөхтэй холбоотой хаалтын үүрэг хариуцлага;
- Төлөвлөгдөөгүй хаалт;
- Барьцаалагдсан тусгай зөвшөөрлийн хаалтын эрх үүргийн асуудлууд юм.

Дээрх эрх зүйн зохицуулалтуудыг судалж үзэхэд ерөнхийдөө уурхайг хаахтай холбоотой нөхөн сэргээлтэд голлон ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудалд бага зэрэг анхаарсан бөгөөд бусад асуудлууд тодорхойгүй, бүрхэг, эсвэл бүрмөсөн орхигдсон байна.

Уурхайн хаалтыг ямар үе шатанд, хэн хэрхэн төлөвлөх, үр дагаврыг нь иж бүрэн хэрхэн үнэлэх, хариуцлагын ямар тогтолцоо байх талаар эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаагаас дараах сөрөг үзэгдэл, үр дагавар, хор хөнөөл учирч болохыг олон улсын болон манай орны уул уурхайн практик харуулж байна.

1. Уурхайн хаалт бол чирэгдэл ихтэй, бэрхшээлтэй үйл ажиллагаа гэж уурхай эрхлэгчид үзэн, эрх зүйн шахалт, хариуцлага тооцох механизм сул бол хэрэгжүүлэлгүй орхиж явдаг.
2. Уурхай гэнэт хаагдахад бэлэн биш учраас хэрхэн хаахаа төлөвлөөгүй, хөрөнгө санхүүжилт бүрдээгүй байдаг.
3. Уурхайн хаалтын чиг баримтлал, хэрэгжүүлэх ажлын цар хүрээ, дэс дараалал боловсруулагдаагүйгээс зөвхөн нөхөн сэргээлт, хаалт хамгаалалт мэтээр ойлгогдож, дутуу дулимаг шийдлийг хэрэгжүүлдэг.
4. Хортой нөлөөлөл нь урт хугацааны дараа илэрч болох зарим төслийн хаалтыг ойр зуурын үйл ажиллагаагаар орлуулан төсөөлөх ба хожмын үр дагаврууд эзэнгүйдэж хөнөөлт үзэгдэл болж хувирах талтай.

Дээр танилцуулсан эрх зүйн орчноос харахад бодлого, эрх зүйн орчинд уурхайн хаалтын талаар нэгдсэн зарчим, цогц ойлголт байхгүй байгаагаас үүдэн уурхайн хаалттай холбоотой заалтууд нь янз бүрийн хуулийн зүйл, заалтууд болж салангид

сууж өгсөн байна. Өөр өөр хуулиар нэг асуудлыг зохицуулж болох боловч уурхайн хаалт гэдэг бодлогын чухал асуудлын зохицуулалтыг өөртөө ямар нэг хэмжээгээр агуулж байна гэж үзэж болох өнөөгийн эрхзүйн актууд ийнхүү хоорондоо уялдаа холбоогүй байна. Энэ байдал нь, тухайлбал, уурхайн хаалттай холбоотой үүргүүдээс зайлсхийх боломжийг уул уурхайн компаниудад олгож байгааг зарим бодит жишээгээр авч үзье:

- АМТХууль-ийн дагуу ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэх, барьцаалах боломжтой бөгөөд шилжүүлэн авсан тал үүсэх эрх үүргийг хүлээн зөвшөөрч байгааг нотлох баримт бичгийг<sup>4</sup> төрийн захиргааны байгууллага шаардахаар заасан боловч тодорхой хуулиудын<sup>5</sup> дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч хуваагдах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд уг тусгай зөвшөөрлөө автоматаар төрийн захиргааны байгууллагад буцаан өгөх замаар хаалтын үүргээс зайлсхийх боломжтой. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрлөө төрд буцаан тушаах нөхцөлд нөхөн сэргээлт, цаашилбал, уурхайн хаалтын асуудал хаягдах боломж үүсээд байгааг манай өнөөгийн эрх зүйн орчин “анзаараагүй” байна.
- АМТХууль-д тусгай зөвшөөрлийг барьцаалагч тал нь уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой үүрэг хүлээхгүй гэж заасан байгаа бөгөөд барьцаанд байгаа уг зөвшөөрлийг эрх бүхий өөр этгээд шилжүүлэн аваагүй тохиолдолд хаалтын асуудал эзэнгүй үлдэж болзошгүй.
- АМТХууль-д тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөөгүй бол уг тусгай зөвшөөрлийг цуцлахаар заасан байгаа бөгөөд зөвшөөрөл цуцлагдсанаас хойш уурхайн хаалтыг хариуцах эзэн нь тодорхойгүй үлдэж байна. АМТХууль-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тусгай зөвшөөрөл цуцлагдсанаас хойшхи зохицуулалтын бүх асуудал

<sup>4</sup> АМТХууль. 7-р бүлэг. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах. 49.4.3. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч буй этгээд нь уг тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаар үүсэх эрх үүргийг хүлээн зөвшөөрч байгааг нотлох баримт бичиг.

<sup>5</sup> АМТХууль. 49.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу хуваагдах, тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд уг тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагад буцааж өгөх

тодорхойгүй, тусгай зөвшөөрлөө хуулийн хугацаанд шинэчлэн бүртгүүлээгүй бол цуцлагдахаар байна. Эрх цуцлагдсанаар уурхайн хаалт эзэнгүйдэх нь гарцаагүй болж байна.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14-р зүйлийн дагуу ашиглалт явуулах тусгай зөвшөөрөл цуцлагдаж болно. Тухайн тохиолдолд мөн хаалтын асуудал эзэнгүй орхигдох юм.

Ихэнх тохиолдолд уурхайн **хаалтыг нөхөн сэргээлт** гэдгээр төсөөлдөг өрөөсгөл ойлголт газар авсан. Уурхайн нөхөн сэргээлт нь хаалтын зайлшгүй бөгөөд нэн чухал хэсэг нь боловч түүнийг бүрэн гүйцэд төсөөлөх үйл ажиллагаа, үр дүн биш юм. Уул уурхайн бүх төсөлд уурхайн хаалтын чиг баримтлал боловсруулагдан бодлого болон хэрэгжих ёстой. Одоогоор бараг бүх төсөлд уурхайн хаалт бус зөвхөн нөхөн сэргээлт гэсэн бүлгийг тусгаж байгаа нь үүний нотолгоо болно. Үүнээс шалтгаалан уурхайн хаалтын зангилаа асуудлууд бүрхэгдэх, орхигдох үзэгдэл нийтлэг шинжтэй байна. Энэ байдлыг цэгцлэхийн тулд уурхайн хаалтын концепцийг боловсруулж, уг үзэл баримтлалын үүднээс өнөөгийн эрх зүйн орчиндоо дүн шинжилгээ хийхээс ажлаа эхлэх ёстой бөгөөд үүнд төрийн байгууллагуудаас гадна мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага болон их дээд сургуулийн судлаачид хамтран ажиллах өргөн боломж нээлттэй байна.

Орхигдоод байгаа дараагийн нэг асуудал бол гэнэтийн хаалтын асуудал бөгөөд Монгол Улсад өнөөдөр гэнэтийн хаалтын асуудлыг тусгасан зохицуулалтын багц боловсруулагдаагүй байна.

Уурхайг хааж улсад, засаг захиргааны нэгжид хүлээлгэн өгөх талаар тусгасан хуулийн заалтууд дараах тохиолдолд сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Газар хөдлөлт, үер ус, салхины аюул зэрэг байгалийн гамшигт үзэгдэл, цаг хугацааны урсгалыг даган үүсч болох өгөршил эвдрэлийн улмаас хаалт хийж хүлээлгэн өгсөн уурхайн объектуудаас ихээхэн цар хүрээтэй аюул нүүрлэвэл хүлээж авсан сум орон нутаг хэрхэн яаж аюул заналыг арилгах, хохирол багатай даван туулах нь тодорхойгүй, хүчин мөхөсдөх тал нь дийлэх урьдчилсан нөхцөл харагдаж байна. Ашиглалт дуусаад хаалт хийгдсэн талбайг

автоматаар буцаан авах процедур бүхий эрх зүй үйлчилж буйг санавал энэ нь бодитой эрсдэл юм.


Дээрх бүгдээс дүгнэж үзэхэд одоогийн байдлаар Монгол Улсад уурхайн хаалтын эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгаатай холбоотой илэрч буй дараах сөрөг үр дагавар, нөлөөлөл байна. Үүнд:

- Алтны шороон орд ашиглахтай холбоотой олон сөрөг үр дагавар гарч байгаа нь нэг доор олон уурхай үйл ажиллагаа явуулсан Төв аймгийн Заамар, Өвөрхангай аймгийн Уянга зэрэг сумдад илүү тодоор ажиглагдаж байна. Үүнийг зохицуулах зорилгоор сүүлийн жилүүдэд байгаль орчныг нөхөн сэргээх талаар төрийн байгууллагаас тавих шаардлагыг нэмэгдүүлж төрөл бүрийн арга хэмжээ авч эхэлж байна<sup>6</sup>. Үүний нэг жишээ нь ашиглалт явагдсан талбайг зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэн хэлбэржүүлэх, гадаргыг ургамалжуулах шаардлага юм. Үр дүнд нь шороон орд олборлож буй салбарт 2008 оны байдлаар нөхөн сэргээлт хийсэн нь төлөвлөсөн хэмжээний 59 хувьд хүрсэн статистик мэдээ<sup>7</sup> гарч байна. Эдгээр талбайг ихэнх тохиолдолд нэгээс хоёр жилийн идэвхитэй үйл ажиллагааны үр дүнд хэлбэржүүлэн, ургамал тарьсны дараагаар тухайн жилд нь төрийн болон орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгсөн бөгөөд дараа жилүүдэд нь ямар нэгэн хяналт, мониторинг хийгдээгүй байна. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийгдсэн гэгдэж буй эдгээр талбайнуудын ургамлын бүрхэвч үнэхээр цаашид биеэ даан оршин тогтож чадсан эсэх, хөрсний бүрхэвч нь хадгалагдан үлдсэн эсэх (Зураг 5.) нь тодорхойгүй юм.

<sup>6</sup> Ашигт малтмалын газраас 2009 онд 1300 га газрыг нөхөн сэргээхээр ажиллаж эхэлжээ. 2010 оны нэгдүгээр сар гэхэд хийсэн ажлын тайлангаа гаргах аж. Харин 2008 онд 930 гаруй га талбайд нөхөн сэргээлт хийгдсэн гэсэн дүн мэдээ байна. Эх сурвалж [http://www.mining.mn/NewsDetails\\_2167.aspx](http://www.mining.mn/NewsDetails_2167.aspx)

<sup>7</sup> Улсын мэргэжлийн хяналтын газраас 19 аймагт ашигт малтмалын хайгуул явуулж буй аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлт хэрхэн хийж буйг шалгажээ. Урьдчилсан байдлаар олборлолтод өртсөн нийт талбай 117 мянга гаруй га газар байгаа аж. Энэ оны байдлаар техникийн нөхөн сэргээлтийг 59 хувь хийсэн байна. Шалгалтын дүнгээр алтны шороон орд олборлогч аж ахуйн нэгжүүдийн техникийн нөхөн сэргээлтийн хэмжээ жилээс жилд нэмэгдсэн ч биологийн нөхөн сэргээлт хангалтгүй байгаа аж. Мөн орон нутагт олборлолт явуулж байгаа томоохон байгууллагууд нөхөн сэргээлт хийдэггүй болох нь уг шалгалтаар тогтоогджээ. Цаашид хуучин олборлолт явуулж байсан газар нөхөн сэргээлт хийсний дараа дахин зөвшөөрөл олгохгүй. Эх сурвалж [http://www.mining.mn/NewsDetails\\_2196.aspx](http://www.mining.mn/NewsDetails_2196.aspx)

- Уул уурхайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хүрээнд орон нутгийн хүн ам, олон нийтийн амьжиргааны бүтэц, төсөлтэй холбогдох тэдний хүлээлт зэргийн талаар суурь судалгаа хийгддэг боловч уурхай хаагдсаны дараа эргэн харьцуулах, судлах, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тогтоох, түүний дагуу арга хэмжээ авах тогтолцоо байхгүй байна. Үүний улмаас өнөөдөр Заамар суманд бэлчээрийн газаргүй болсон малчдын асуудал, малчин байгаад амьжиргааны эх үүсвэр нь өөрчлөгдсөн иргэдийн асуудал зэрэг олон шийдвэрлэгдээгүй асуудлууд бий болжээ.



Зураг 5. Нөхөн сэргээлт хийсэн талбайд гарах үзэгдэл ба нөлөөлөл

- Сүүлийн жилүүдэд алтны шороон ордуудын ашиглалт идэвхитэй явагдсантай холбоотой уул уурхайн нөхөн сэргээлтийн журам, заавруудыг тухайн төрлийн уурхайнуудад илүү нийцүүлэн боловсруулсан байна. Энэ нь бусад төрлийн уурхайд ашиглахад тохиромж муутай, мэргэжлийн хүрээнд болон олон нийтийн зүгээс уурхайн хаалтын олон хувилбарт шийдэл, үйл явцыг төлөвлөж хэрэгжүүлэх цаг хугацааны хуваарилалт, хөрөнгө мөнгөний төлөвлөлт, зарцуулалтын талаар хүлээн зөвшөөрөх сэтгэлзүй, мэргэшсэн байр сууринаас хандах хандлага бүрэлдэж амжаагүй байгааг харуулж байна.

- Уурхай бүрийн хаалт харилцан адилгүй орчин нөхцөлд явагдах тул өөр өөрийн тодорхой чиг баримтлал буюу эцсийн зорилготой байна.
- Уурхайн хаалтын ажиллагаа нь аюулгүй орчинг хангах ба ашигтай орчин бүрдүүлэх үндсэн хоёр гол чиг баримтлалын хүрээнд хэрэгжинэ. Уурхайн хаалтын чиг баримтлалыг хураангуй байдлаар дараах хүснэгтэд тусгав.

### Уурхайн хаалтын чиг баримтлал<sup>8</sup>

д/д	Чиг баримтлал	Агуулга
1	Аюулгүй орчин бүрдүүлэх	Хүн, мал, амьтны оршин амьдрах газар, усны тохиромжтой, аюулгүй орчинг хааж байгаа уурхайн эдэлбэрийн хүрээнд бий болгох.
2	Ашигтай орчин бүрдүүлэх	Хаах уурхайн эдэлбэрийн хүрээнд: <ul style="list-style-type: none"> <li>а. Бэлчээр, хадлан, ногооны талбай үүсгэж хөдөө аж ахуйн эдэлбэр бий болгох</li> <li>б. Ой, цэцэрлэгт хүрээлэн, жимсний цэцэрлэг зэрэг ойн аж ахуйн эдэлбэр бий болгох</li> <li>в. Загас, шувуу үржүүлэх усны эдэлбэр бий болгох</li> <li>г. Хөдөө аж ахуй ба ойн аж ахуйн цогцолбор үүсгэх</li> <li>д. Хотын ба үйлдвэрийн хог хаягдлыг булшлах хураагуур байгуулах</li> <li>е. Химийн хортой ба цацраг идэвхит бодисын хаягдал булшлах гүний байгууламж үүсгэх</li> <li>ё. Амралт, зугаалга, спортын цогцолбор байгуулах</li> <li>ж. Эмчилгээ сувиллын бүс байгуулах</li> <li>и. Цэвэр усны нөөцийн сан бий болгох</li> <li>к. Үйлдвэрлэл технологийн байгууламж, агуулах болгон ашиглах</li> <li>л. Сургалт, туршилт судалгааны объект болгох</li> <li>м. Музей, үзүүлбэр болгох</li> </ul>

<sup>8</sup> С. Цэдэндорж, Ц.Амарсайхан. Уурхайн хаалтын чиг баримтлал. ЭШ-н 37-р бага хурал 2009, Уул уурхайн технологи, эдийн засаг, экологи, геодези, газрын харилцаа. УБ 2009, 4-6х


### 3. УУРХАЙН ХААЛТЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БИЙ БОЛГОХ АРГА ЗАМУУД

Өнөөг хүртэл Монгол Улсын уул уурхайн нөхөн сэргээлт, хаалтад чиглэсэн эрх зүйн зохицуулалт хийж ирсэн туршлага, хууль эрх зүйн орчныг судалж үзэхэд уул уурхайн үйл ажиллагааны улмаас үүсэж бий болсон хүндрэл, бэрхшээлтэй асуудлуудыг гарсан хойно нь зохицуулах арга хэмжээ авах байдлаар ажилладаг арга барил ажиглагдаж байна. Мөн уурхайн хаалтын байгаль орчны холбоотой асуудлыг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид үүрүүлж, дагалдаж бий болсон нийгмийн болон эдийн засгийн хүндрэлтэй асуудлуудыг төр өөртөө хүлээдэг хандлага байна.

Энэ туршлагаар цааш явах тохиолдолд ойрын 5 жилээс эхлэн өмнө нь бидний хувьд хаалт хийж байсан туршлага байхгүй, алтны үндсэн орд, зэсийн болон төмрийн хүдрийн орд зэргийг ашигласан, их гүнтэй уурхай, баяжуулах процесст хүхрийн хүчил, цианид зэрэг химийн хорт бодисууд ашигласан уурхайнуудын хаалтын асуудлууд тулгарч ирэхээр байна. Нийгэм, эдийн засгийн үр нөлөөгөөрөө ч эдгээр уурхайнуудын хаалт нь бүс нутгийн болон улс орны хэмжээний асуудал байх болно.

Иймд манай өнөөгийн **асуудалд хөтлөгдсөн** зохицуулах тогтолцоог **урьдчилан төлөвлөн зохицуулсан** тогтолцоонд шилжүүлэх, хаалтын үр дагаварыг компани – төр хуваалцаж буй хуваарилалтыг илүү оновчтой болгох хувилбарыг дэвшүүлэн, харьцуулалт хийв.





Зураг 6. Уурхайн хаалтыг зохицуулах хувилбаруудын харьцуулалт

Бидний санал болгож буй энэ схемээр уурхайн хаалтын эрхзүйн зохицуулалтыг боловсруулах нь нэгдүгээрт өмнөх бүлэгт өгүүлсэн 10 асуудлыг иж бүрэн хамарсан, хоорондоо уялдаа бүхий хууль, журам, заавар стандартуудыг цогцоор бүрдүүлэх болно. Үүний тулд мөн өмнөх бүлэгт дурьдсан хуулиуд, шинээр гарах “Уул уурхайн тухай хууль”-д уурхайн хаалттай холбоотой тодорхой бүлгүүд, заалтуудыг оруулахаас гадна схемийн шат бүрд харгалзах журам, зааврууд гарах ёстой.

Мөн энэ шинэ зохицуулгатай холбогдуулан судлаачдын зүгээс “Уурхайн хаалтын нэр томъёоны тодорхойлолт”-ын стандарт болон “Гүний тогтоцтой ордын ашиглалт, хаалтын үед аюулгүй ба ашигтай орчин бүрдүүлэхэд баримтлах журам”-ын саналуудыг хавсаргав.

#### 4. ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын явцад цуглуулсан мэдээлэл, баримтуудад тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Өнөөдрийн эрх зүйн зохицуулалт уурхайн хаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хангалтгүй, хоорондын уялдаа холбоо сул байна. Уурхайн хаалт, хаалтын дараах хяналт, хаалт хийгдсэн талбайг орон нутагт буцаан хүлээлгэж өгөх зэрэг асуудлууд нь бүгд тодорхой зохицуулагдах ёстой. Цаашилбал, уурхайн хаалт хийгдэж орон нутагт буцаан хүлээж авсан талбайг өөр зориулалтаар ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан тогтолцоо шаардлагатай.
- Уул уурхайн үйл ажиллагаа нь олборлох ашигт малтмалаас хамааран олон янз бөгөөд түүний улмаас үүсэх олон талт тусгал, үр нөлөөллийг бүрэн шийдвэрлэхэд Монгол Улсын өнөөгийн хууль эрх зүйн актууд хангалтгүй, уурхайн хаалттай холбоотой нийгэм эдийн засгийн асуудлууд орхигдсон, олон нийтийн хяналтын механизм сул байна.
- Уурхайн хаалттай холбоотой стандартууд дутагдалтай, их гүнтэй хүдрийн уурхайнууд, уран зэрэг цацраг идэвхит орд ашиглах уурхайнуудын хаалтын зохицуулалт дутагдалтай байна.
- Уурхайн хаалтын асуудлыг эрх зүйн хувьд бүрэн зохицуулах, хууль, журмуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна. Лиценз эзэмшигчээс нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө авдаг тогтолцоог төгөлдөршүүлж уурхайн хаалтын зардлын барьцаа авдаг, хаалтын даатгал бүхий эрх зүйт тогтолцоо уруу шилжих нь зохистой байна.
- Хаалт, нөхөн сэргээлт, дагалдах нийгмийн асуудал нь зөвхөн ашиглалтын лиценз эзэмшигчийн хүрээнд шийдвэрлэгдэх асуудал биш бөгөөд төрийн зүгээс нэг бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй уурхайнуудын хаалтын асуудлыг нэгтгэн зангидаж, чиглүүлдэг тогтолцоо шаардлагатай.

- Хаалт хийгдсэн уурхайг буцаан хүлээж авахад орон нутгийн засаг захиргааны чадавхи дутагдана. Иймд уурхайн талбайг буцаан хүлээж авах үйл явцыг хөндлөнгийн мэргэжлийн шинжээч, олон нийтийн оролцоотой шийддэг тогтолцоог бий болгох хэрэгтэй.

## 5. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад уурхайн хаалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой дараах санал зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

*Холбогдох хууль эрхзүйн актуудад өөрчлөлт оруулах талаар*

Уурхайн хаалтын эрх зүйн зохицуулалтыг АМТХууль-д нэмэлт өөрчлөлт оруулах буюу эсвэл яригдаж буй Уул уурхайн хуулийг шинээр боловсруулахад уурхайн хаалтын асуудлыг бие даасан бүлэг болгон оруулах замаар боловсронгуй болгох, хуулийн хүрээнд дараах асуудлуудыг шийдвэрлэх нь ач холбогдолтой:

- Уурхайн хаалтын чиг баримтлалыг ордыг ашиглах ТЭЗҮ-д тусгаж түүнийг голлох асуудлуудаар нь шийдвэрлэх үйл ажиллагааны цар хүрээ, хэмжээ, хугацаа ба шаардагдах зардлыг тооцсон байх;
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдөхөд уурхайн хаалтын үүрэг хариуцлага даган шилждэг, зөвшөөрөл барьцаалагдах зэрэг ямар ч тохиолдолд уг үүрэг эзэнгүйдэж орхигдохгүй байх;
- Төслийг эхлүүлэх үед хаалтын төлөвлөгөөг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх шатуудад байнга шинэчлэн сайжруулж, хаах шатанд зохих ёсоор хэрэгжүүлэх арга ажиллагаа, үйл явцыг зааж өгөх;
- Хаалтын зардлыг төслийн эхнээс хуримтлуулах, даатгалын санд байршуулах тогтолцоог бий болгох
- Хаалтын зардлын барьцааг газрын үнэлгээтэй уялдуулах нөхцөлийг хангах;
- Уурхайн хаалтын зардлын эрсдэлийн даатгалын тогтолцоо бий болгох;
- Уул уурхайн төслийн явц, хэрэгжилт, хаалтын төлөвлөгөөний шинэчлэлтийг тодорхой хугацаанд эргэн хянадаг, хаалтын зардлын тооцоонд аудит хийдэг тогтолцоог бий болгох;

- Уурхайн хаалт хийгдсэн талбайг орон нутаг буцааж хүлээж авах эсвэл, компани хаагдсан уурхайн нийт талбай, объектыг хараа хяналтандаа зайлшгүй байлгах хариуцлага хүлээх асуудлыг тодорхой зааж өгөх;
- Хаалтын дараах хяналт мониторингитой холбоотой үүрэг хариуцлагыг тодорхой болгох;
- Арилжааны банкууд ашиглалтын онцгой эрх авсан субъектэд зээл олгохдоо барьцааны активт нь нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг нэг аргумент болгож байх зэрэг болно.

*Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг оновчтой болгох талаар*

Асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын үүргийг дараах байдлаар тодотгох:

- Орд ашиглах ТЭЗҮ-д уурхайн хаалтын чиг баримтлал, төлөвлөлт, санхүүжилт гэсэн бүлгийг тусгах талаар ТЭЗҮ хэлэлцэх, хүлээн авах журамд тусгах;
- Хаалт хийж уурхайн нөөцийн хөдөлгөөний тайлан гаргуулан улсын нөөцийн бүртгэлд тусгуулж, нөөц шавхагдсан, дутуу ашигласан зэрэг баримт бүрдүүлж архивлах;
- Түр хаах уурхайг сэргээн ашиглахад баримтлах журмыг боловсруулж мөрдүүлэх;
- Бүрмөсөн хаах уурхайн хаалтын журмыг боловсруулж мөрдүүлэх;
- Уурхайн гэнэтийн хаалтын холбогдолтой журам боловсруулж мөрдүүлэх;
- Уурхайн хаалтын төслийн баримт бичгийг аюулгүй нөхцөл талаас мэргэжлийн хяналтын байгууллага; байгаль орчныг хамгаалах, экологийн тогтвортой нөхцөл талаас байгаль орчны хяналтын байгууллага; нөөцийг бүрэн гүйцэд ашиглах талаас ЭБЗ, кадастрын алба, батлах, мэргэжлийн хяналт, бүртгэл тооцоо хийх;

- Уурхайн хаалтын нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг багасгах, ба ашигтай үр дагаврыг нэмэгдүүлэх талаар орон нутгийн засаг захиргаа үүрэг хүлээх;
- Аюултай, хортой орчин бүрдүүлэх уурхайн хаалтын журмыг тусгайлан боловсруулж мөрдүүлэх;
- Уурхайн хаалтын холбогдолтой нэр томъёо, нийтлэг баримтлал, шаардлага, үзүүлэлт, хэмжээсийг тусгасан Монгол Улсын стандарт боловсруулах;
- Хаагдсан уурхайн мониторингийн тухай журам боловсруулж мөрдөх шаардлагатай байна.

*Компаниудын уурхайн хаалтын талаар нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх талаар*

- Уул уурхайн төсөл бүрт хаалтын чиг баримтлал, төлөвлөгөө, санхүүжилтийн бодлогыг тусгаж хэрэгжүүлэх;
- Уурхайн хаалтын холбогдолтой ажлыг жил бүрийн төлөвлөгөө тайланд тусгах баримтлалыг бий болгох;
- Уурхайн ашиглалтын явцад гарч буй өөрчлөлт, хувиралтыг бодолцон хаалтын цогц асуудалд тодотгол, шинэчлэл хийж байх;
- Уурхайн хаалтын ажлуудыг орон нутгийн нийгэм, эдийн засаг, хүмүүсийн санаа хүсэлд нийцүүлэн хэрэгжүүлэхэд санаачлагатай хандах;
- Ашиглалтын болон хаалтын эрх шилжүүлэх асуудлыг холбогдох хууль эрхийн хүрээнд хариуцлагатай хэрэгжүүлэх;
- Аюултай хортой орчин бүрдэх уурхайн хаалт ба хаалтын дараах урт хугацааны үр дагаврыг хариуцаж аюулыг гэтлэх үүрэг хүлээх;
- Бүс нутгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд уурхайн хаалтыг нийцүүлэн хэрэгжүүлэх шаадлагатай байна.

*Олон нийт, ТББ-уудын хяналт, оролцоог нэмэгдүүлэх талаар*

- Уул уурхайн компанийн хаалтын зардлын санг олон нийтэд нээлттэй мэдээлдэг механизмыг бүрдүүлэх;
- Компанийн уурхайн хаалтын төлөвлөгөөнд хөндлөнгийн шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийг тодорхой хугацаанд давтан хийлгэж үр дүнг олон нийтэд мэдээлэх механизмыг бүрдүүлэх;
- Тухайн орон нутагт уурхайн нөхөн сэргээлт, хаалтын ажиллагаанд малчдынх нь идэвхи оролцоог бий болгох.





МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Уул уурхай.  
Уурхайн хаалт  
Нэр томъёо, тодорхойлолт**

**MNS..... :2010**

АЛБАН ХЭВЛЭЛ

СТАНДАРТЧИЛАЛ ХЭМЖИЛЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Улаанбаатар хот

2010он

**MNS..... : 2010****Өмнөх үг**

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв (СХҮТ) нь Олон Улсын Стандартчиллын Байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хороо хурлаар хэлэлцэж 75-аас доошгүй хувиар дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөл (СХҮЗ)-өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартын төслийг **Нээлттэй Нийгэм Форумын “Уурхайн хаалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь”** сэдэвт хөтөлбөрийн судалгааны бодлогын ахлах судлаачийн баг боловсруулав.

Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандартуудтай нийцүүлэн хянасан.

Уг стандартыг Байгаль орчны стандартчиллын техникийн хороо, Уул уурхай ашигт малтмалын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэж дэмжсэн болно.

**Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв (СХҮТ)****Энхтайваны өргөн чөлөө 46А****Улаанбаатар 13343, Ш/Х-48****УТАС 51-263860 Факс (976-11) 263860****E-mail: [www.standardinform@masm.gov.mn](http://www.standardinform@masm.gov.mn),****[www.estandard.mn](http://www.estandard.mn)**

## СХҮТ 2010

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай”  
Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХҮТ (Стандартчиллын төв байгууллага-д) байна.

### Монгол Улсын стандарт

#### Ангилалтын код .....

Уул уурхай.

Уурхайн хаалт. Нэр томъёо, тодорхойлолт

MNS ..... : 2010

Mining.

Mining closure. Terms and definitions

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2010 оны ..... дүгээр сарын ..... өдрийн .... дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2010 оны ..... дугаар сарын ..... ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

#### 1. Зорилго

Энэ стандартын зорилго нь уул уурхайн үйлдвэрийн хаалттай холбогдолтой нэр томъёо, тодорхойлолтыг тогтооход оршино.

#### 2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт баримт бичгүүдийг хэрэглэв. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ. Үүнд:

- MNS 5914: 2008, Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
- MNS 5915: 2008, Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал

- MNS 5916 : 2008, Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS 5917 : 2008, Байгаль орчин. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5918 : 2008, Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага

### 3. Ерөнхий зүйл

#### 3.1. Уурхайн хаалт

Ашигт малтмалын орд буюу эсвэл түүний хэсэгт уурхайн ашиглалтыг дуусгавар болгох ажиллагаа.

#### 3.2. Уурхайн бүрмөсөн хаалт

Уурхайд ашигт малтмал олборлох уулын ажлуудыг бүрмөсөн зогсоох ажиллагаа.

#### 3.3. Уурхайн түр хаалт

Уурхайг хожим нь сэргээн ашиглахаар бодолцож уулын ажлыг зогсоох ажиллагаа.

#### 3.4. Уурхайн гэнэтийн хаалт

Аюулгүйн нөхцөл алдагдах, эдийн засгийн үр ашиг унах, байгаль орчны доройтол даамжрах, нийгмийн зүгээс эсрэгшил бий болох, компани үйлдвэрлэл үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, эрх зүйн чадамжгүй болох зэргээс шалтгаалан төлөвлөснөөс өмнө уурхайн уулын ажлыг зогсоох ажиллагаа.

#### 3.5. Уурхайн хаалтын ерөнхий баримтлал

Уурхайн хаалтаар аюулгүй ба ашигтай орчин бүрдүүлэх үйл ажиллагаа.

#### 3.6. Уурхайн хаалтаар аюулгүй орчин бүрдүүлэх чиг баримтлал

Хүн, мал амьтны оршин амьдрах газар усны тохиромжтой, аюулгүй орчинг хаах уурхайн эдэлбэрийн хүрээнд бий болгох чиг баримтлал.

### 3.7. Уурхайн хаалтаар ашигтай орчин бүрдүүлэх чиг баримтлал

Хаах уурхайн эдэлбэрийн хүрээнд хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас шувууны аж ахуй, эдгээрийн хосломол аж ахуй бий болгох, хотын ба барилгын хог хаягдал булшлах, хортой, цацраг идэвхит хаягдал булшлах хураагуур байгуулах, амралт, спортын цогцолбор, эмчилгээ сувилгааны бүс, цэвэр усны сан, технологийн байгууламж, агуулах, сургалт туршилтын объект, музей үзүүлбэр бий болгох чиг баримтлал.

### 3.8. Уурхайн хаалтын төсөл

Уурхайн ашиглалтын төслийн баримт бичиг дэх хаалтын төслийн бүлэг эсвэл зөвхөн хаалтыг тусгасан төслийн баримт бичиг.

### 3.9. Уурхайн хаалтын төлөвлөгөө

Ашиглалтын эхнээс төгсгөл хүртэлх бүх хугацааны турш ээлж дараатай явуулах хаалтын ажлын хуваарилалт.

### 3.10. Уурхайн хаалтын хүрээнд шийдэх асуудал

Хаагдах уурхайн үүсмэл орчин, орон зайн бүрдлийг аюулгүй болгох, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, бүрэлдэж бий болсон дэд бүтэц, барилга байгууламжийг үр ашигтай ашиглах эсвэл хор хөнөөлгүй болгох, бүс нутаг, аймаг сумын хүн амын нийгэм эдийн засагт тусах сөрөг нөлөөллийг багасгах ажиллагаа.

### 3.11. Уурхайн хаалтын төсөв

Сонгосон чиг баримтлалын дагуу явуулах уурхайн хаалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх зардлын хэмжээ.

### 3.12. Уурхайн хаалтын эрхзүйн зохицуулалт

Байгаль, нийгэм, эдийн засаг технологийн шинж чанар бүхий үйл явц болох уурхайн хаалтыг зохицуулах Монгол Улсын хууль, хуульчилсан

дүрэм, журам заавруудыг хэрэгжүүлэх, хянах ажиллагаа.

### **3.13. Уурхайн хаалтыг хариуцах субъект**

Уурхайд ашиглалт явуулж буй хуулийн этгээд болох аж ахуйн нэгж буюу эсвэл хаалтын үүрэг хариуцлагыг хүлээхээр тогтож эрх шилжүүлэн авсан хуулийн этгээд.

### **3.14. Хаагдсан уурхайг хүлээлгэн өгөх хэлбэр**

Орон нутгийн төрийн байгууллагад бүтэн хэмжээгээр бүрмөсөн ба хэсэгчилсэн байдлаар зарим объектыг хүлээлгэн өгөх буюу эсвэл хаалтын дараа тодорхой үйл ажиллагаа явуулах субъектэд өгөх.

### **3.15. Хаагдсан уурхайг орон нутагт бүрмөсөн хүлээлгэн өгөх хэлбэр**

Хаалтын ажлын хүрээнд аюулгүй ба ашигтай байдлаар нь бүрэн хаагдсан уурхайн эдэлбэрийг хүлээлгэн өгөх.

### **3.16. Хаагдсан уурхайн объектуудаас хэсэгчлэн хүлээлгэн өгөх хэлбэр**

Аюулгүй ба ашигтай байдал нь хаалтаар хангагдсан объектуудыг орон нутагт хүлээлгэн өгөх ба эрсдэл бүхий объектууд компанийн хариуцлагын хүрээнд үлдэх.

### **3.17. Хаалтын дараа тодорхой үйл ажиллагаа явуулах субъектэд уурхайг хүлээлгэн өгөх хэлбэр**

Уурхайн хаалтын чиг баримтлалын дагуу ашигтай үйл ажиллагааны боломж бүрдүүлж үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ашиглалт явуулах субъектэд хүлээлгэн өгөх .

### **3.18. Уурхайн хаалт хийсэн талбайг хүлээж авахаас түтгэлзэх хэлбэр**

Аюулгүйн нөхцөл талаас тодорхой эрсдэл бүхий хаагдсан уурхайн объектуудыг компанийн

хариуцлагын хүрээнд туршилтын хугацаа зааж үлдээх.

### **3.19. Хаагдсан уурхайн ажиглалт, хяналт**

Хаагдсан уурхайн хүрээний объектуудад ажиглалт, хяналтыг урт хугацаанд хэрэгжүүлэх ажиллагаа.

### **3.20. Уурхайн хаалтын дараах эрсдэлийн даатгал**

Болзошгүй хувиралт өөрчлөлтийн улмаас гарч болох эрсдэлийг даван туулахад зориулсан даатгалын тогтолцоо.

**Гүний тогтоцтой ордын ашиглалт, хаалтын  
үед аюулгүй ба ашигтай орчин бүрдүүлэхэд  
баримтлах журамд тусгах заалтууд  
(Журмын санал)**



Гүний тогтоцтой ашигт малтмалын ордод ил аргаар ашиглалт явуулах, хаалт хийх үе шатанд аюулгүй ба ашигтай орчин бүрдүүлэх нийтлэг үзэл санааг баримтлана.

## **АЮУЛГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИМТЛАЛ**

Нэг. Ил уурхайн хүрээ

- 1.1. Ил уурхайн ашиглалтын хүрээг төслөөр тооцож уурхайлах талбайн хүрээг тогтоох ба дэвсгэр зургууд ба зүсэлтүүд дээр тэмдэглэнэ.
- 1.2. Ашиглалтын хүрээг нь шууд тогтоох боломжгүй үе шатаар шийдэх ордод хэтийн ирээдүй бүхий талбайн заагийг тогтооно.
- 1.3. Ашиглалтын хүрээнээс гадагш үүсэж болох эвдрэл, хагарлын бүсийн заагийг тогтоож холбогдох зургуудад тусгана.
- 1.4. Ил уурхайн хүрээнээс гадагш эрүүл ахуйн цээрийн бүсийн заагийг тогтоож холбогдох зургуудад тусгана.
- 1.5. Ашиглалтын явцад эдгээр бүсүүдийн шугамыг уурхайн эдэлбэр талбайд тэмдэгжүүлнэ.

Хоёр. Овоолго

- 2.1 Ил уурхайгаас үүсэх шимт хөрс, хоосон хөрс, аж ахуйн эрэлт бүхий чулуулаг, кондицийн бус (ядуу хүдэр, технологийн шаардлага хангахгүй бусад хүдэр) хүдрийн төрөлжсөн овоолгуудын эзлэхүүн, талбайн тооцоог төслөөр хийнэ.
- 2.2 Эдгээрийг зургуудад тусгах ба ашиглалтын явцад зааг хүрээг эдэлбэрийн талбайд тэмдэгжүүлнэ.
- 2.3 Овоолгоос тоосролт, хийн ялгаралт, хүчиллэг орчин үүсэх талбайнуудын заагийг тогтооно.

### Гурав. Боловсруулах үйлдвэр

- 3.1 Боловсруулах үйлдвэрийн хаядасны сан, хураагуурын эзлэх орон зай, талбайг тооцож тогтооно.
- 3.2 Хаядасны хураагуур, эргэлтийн усны сангаас эрсдэл үүсч болох талбайн зааг, бүсийг тогтооно.

### Дөрөв. Үйлдвэрийн талбай

- 4.1 Үйлдвэрлэлийн талбайн хүрээнд барилга, байгууламжийн эзлэх талбайн зааг хязгаар, тэдгээрийн холбоос, зохистой төлөвлөлтийг төслөөр шийднэ.
- 4.2 Галын аюулгүйн нөхцөлийг баримталж байгууламжуудын байршлыг тогтооно.
- 4.3 Тэсрэх материал, шатах тослох материал болон бусад аюултай бодис, материалын агуулахын байршлыг төслөөр тооцож тогтооно.
- 4.4 Газар хөдлөлт, үер ус, салхи, аянга зэрэг байгалийн үзэгдлээс бүрэн хамгаалах нөхцөлийг төслөөр тооцож тогтооно.
- 4.5 Дэд бүтэц (тээвэр, цахилгаан, ус, дулаан) төлөвлөлтийн оновчтой шийдлийг төсөлд тооцож тусгана.

### Тав. Ил уурхайн элементүүд

- 5.1 Ил уурхайн элементүүдийг төслийн судалгаа, тооцооны дагуу бүрдүүлнэ.
- 5.2 Ил уурхайн доголын өндрийг төслийн үндэслэлээр тогтооно.
  - 5.1.1 Хаагдах догол нь дан ба нэгтгэсэн (2 ба 3) хэлбэрээр хэлбэршиж болно.
  - 5.1.2 Хаагдах доголын тогтвортой байдлыг хангахын тулд хувааж дэд доголууд болгон хэлбэршүүлж болно.
- 5.3 Догол дахь талбай тавцанг төслөөр тогтооно.
  - 5.3.1 Доголын аюулгүйн тавцангийн өргөн нь доголын өндрийн гуравны нэгээс багагүй өргөнтэй байна.

- 5.3.2. Нэгтгэсэн доголын аюулгүйн тавцангийн өргөн нэгтгэсэн нийт өндрийн гуравны нэгээс багагүй байна.
  - 5.3.3. Аюулгүйн тавцан дээр жижиг оврын техник ажиллаж доголын ирмэг, хажуунаас нурж, эмтэрч буусан чулуулгийг цэвэрлэх боломжийг бүрдүүлнэ.
  - 5.3.4. Догол дахь тээврийн тавцанг төслийн тооцоогоор тогтооно.
  - 5.3.5. Ил уурхайн доголудыг нээсэн траншей хоорондын уулзвар талбайн урт өргөнийг (хийцийг) төслөөр тогтооно.
- 5.4 Хаагдах доголын хажуугийн өнцгийг төслийн судалгаа тооцоогоор тогтооно.
- 5.4.1 Хаагдах доголын хажуугийн өнцөг нь тогтвортой нөхцөлийг хангах ба догол бүрт, доголын шугам бүрт ялгаатай байж болно.
  - 5.4.2. Доголын хажуугийн тогтвортой байдал хангагдахгүй тохиолдолд бэхлэх, бөхжүүлэх нэмэлт арга ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 5.4.3. Доголын хажуугийн тогтвортой байх нөхцөлийг тухайн чулуулгийн байгалийн налуугийн өнцөгтэй холбож үзнэ.
- 5.5 Ил уурхайн хажуугийн болон булан хэсгүүдийн бүтцийг төслөөр тогтооно.
- 5.5.1 Ил уурхайн хажуугийн өнцөг нь ашиглалтын (гүний) бүсүүдэд ялгаатай байж болно.
  - 5.5.2. Ил уурхайн хажуугийн өнцөг нь урт хугацаанд хажуу тогтвортой байх нөхцөлийг хангана.
  - 5.5.3. Ил уурхайн хажуу дахь тогтворжилтыг хангах зорилгоор бэхлэлт, бөхжүүлэлт хийнэ.
  - 5.5.4. Ил уурхайн хажуу, түүнийг бүрдүүлэгч доголын элементүүдэд байнгын ажиглалт, тандалт хийж аюулгүйн магадлалыг хангаж байна.

- 5.6 Ил уурхайн зам тээврийн системийг төслийн тооцоогоор бүрдүүлнэ.
- 5.6.1. Ил уурхайн замын ерөнхий чигийн элементүүд болох дагуу налуу, хөндлөн налуу, тойруугийн радиус, шулуун болон тойруу хэсгүүдийн холбоос, уулзвар талбайн хэмжээсүүдийг төслөөр тогтооно.
- 5.6.2. Замын дагуу налуу нь зөвшөөрөгдөх налуугаас ихгүй байна.
- 5.6.3. Хөндлөн налуу нь хэсэг тус бүрт ялгаатай тогтоогдох ба тойруу хэсэгт төвөөс зугтах хүчний үйлчлэлээс сэргийлэх, шулуун хэсгүүдэд задгай ирмэг талруу хазайхаас сэргийлэх зориулалттай байна.
- 5.6.4. Урт өгсүүрт хөдөлгүүрийн хэт ачаалал, хөдөлгөөний аюулгүйн нөхцөл хангах зорилгоор 500 м зай бүрт хэвтээ хэсгийг бүрдүүлнэ.
- 5.7 Ил уурхайн хүрээний хэлбэршилтийг тогтвортой байдлыг хангахад чиглүүлж төслөөр шийднэ.
- 5.7.1. Ил уурхайн хүрээний шугам дахь гадаргуу хотгор бол тогтворжилтын нөхцөл сайтай, гүдгэр бол уулын даралтын хүчний нөлөөгөөр эвдрэлд орох хандлагатай болохыг бодолцоно.
- 5.7.2. Ашиглалтын явцад уурхайн хүрээний дагуух гадаргуугийн хэлбэршилтээс үүсэлтэй эвдрэлүүдийг газар авхуулахгүй засах залруулах ажил шаардагдана.

Зургаа. Ил уурхайн хаалтын баримтлал

- 6.1. Ашиглалтын дараа хэлбэрээ хадгалан үлдэх ил уурхайн ухшийг аюулгүй нөхцөлөөр хэлбэршүүлэх.
- 6.1.1. Ил уурхайд үүсэх бүх ажлын бус доголыг тогтвортой байх нөхцөлөөр хангана.
- 6.1.2. Ил уурхайд амсраас ёроол хүртэл зам харилцааны сүлжээг төгсгөлийн догол ашиглах нөхцөлөөр нь хадгалан үлдээнэ.

- 6.1.3. Хаагдсан доголлуудад нэг бүрчлэн үзлэг хийж аюулгүй, тогтвортой нөхцөлөөр дүгнэлт гаргаж акт үйлдэнэ. Уг баримтыг архивлана.
- 6.1.4. Уурхайн хаагдсан доголлуудаас хийн ялгаралт, исэлдэлтийн хортой үүсэл гарах эсэхийг шинжилж дүгнэлт гаргана.
- 6.1.51. Хортой үүсэл, ялгаралт гарах тохиолдолд булшлах, саармагжуулах нэмэлт ажлыг хэрэгжүүлнэ.
- 6.1.6. Ач холбогдол багатай буюу, хор холбогдолтой гүний усны шүүрэлтийг зогсоох ажлыг хэрэгжүүлнэ.
- 6.1.7. Тоосрох гадаргуу ихтэй уурхайн хажуу, доголд цементжүүлэх, барьцалдуулах нэмэлт ажлыг хэрэгжүүлнэ.
- 6.1.8. Ил уурхайн ухашны тогтвортой аюулгүй байдлыг хянах ажиглалтын цэгүүдийг байгуулж хяналтын хэмжилтийг тогтсон хугацаанд тогтмол явуулна.
- 6.1.6. Ил уурхайн ухашны хүрээнээс гадагш хагарал, сулралын бүс үүсч буй эсэхэд тогтмол хяналт тавина.
- 6.2. Ашиглалтын дараа хог хаягдлыг булшлах чиглэлээр ашиглах ил уурхайн ухшийг аюулгүй нөхцөлөөр хэлбэршүүлэх.
  - 6.2.1. Ил уурхайн ухшинд үүссэн бүх догол, хажуу зэргийн тогтворжилтыг хангана.
  - 6.2.2. Уурхайн доголлуудаас ялгарч болох хортой зүйлийг саармагжуулах, зогсоох ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 6.2.3. Хог хаягдлын санд шинээр хортой хуримтлал бүрэлдэхээс сэргийлнэ.
  - 6.2.4. Хог хаягдлын зүйл уурхайн чулуулгийн ан цаваар нэвчиж орчинд тархах, гүний усыг бохирдуулахаас сэргийлж ёроол, хажуугийн гадаргууд шаваас, хучаас (шавар зэрэг материал) болон үе шат бүрт нягтруулалт, битүүмжлэл хийнэ.
  - 6.2.5. Хог хаягдлын төрөл зүйлд тохируулж хоргүйжүүлэх, саармагжуулах, арга ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 6.2.6. Ил уурхайн ухшинд химийн хортой, цацраг идэвхитэй, бактерилогийн аюултай хаягдлыг хураахаас зайлсхийнэ.
- 6.3. Ашиглалтын дараа тусгай зориулалтын байгууламж, аялал жуулчлалын зориулалтаар ашиглах ил уурхайн ухшийг аюулгүй нөхцөлөөр хэлбэршүүлэх.
- 6.3.1. Бартаат замын уралдааны талбар, уулын спортын дасгалын полигон зэрэг чиглэлээр ашиглахад тухайн спортын тамирчдын ба үзэгч сонирхогчдын аюулгүйн нөхцөлийг хангана.
- 6.3.2. Үзмэр, музей, судалгаа сургалтын зориулалтаар ашиглах ил уурхайн ухшинд холбогдох бүх аюулгүйн нөхцөлийг бүрдүүлэх ба тоног төхөөрөмж, байгууламж, тээврийн сүлжээнд хэвийн ашиглалтын байдлыг хадгална.
- 6.3.3. Зэргэлдээ уурхайн хоосон чулуулгийн овоолгыг хаагдах уурхайн ухшинд хожим хураах тохиолдолд ил уурхайн зам харилцааны системийг бүрэн хадгалан үлдээж дүүргэлт хийх ажлыг системтэй явуулна.
- 6.3.4. Аялал зугаалгын объект болгон ашиглах тохиолдолд уурхайн ухаш дотор үзүүлбэр зохион байгуулахад зөвшөөрөх маршрутын дагуу аюулгүйн нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.3.5. Үйлдвэрлэл, ахуйн хэрэгцээг хангах усан санг уурхайн ухшинд үүсгэж ашиглах тохиолдолд усны чанарыг хангах, хяналт, ашиглалтын нэмэлт байгууламж байгуулах ба аюулгүйн нөхцөлийг бүрэн хангана.
- 6.3.6. Загас, шувуу үржүүлэх зориулалтаар ашиглах усан сангийн усны чанарыг хангах, нэмэлт байгууламжууд, ашиглалтын төхөөрөмжөөр (завь, зогсоол, болон бусад) тоноглоно.
- 6.3.7. Уурхайн ухшинд аялал зугаалгын зориулалттай цөөрөм, наран шарлагын газар байгуулах тохиолдолд эргээс нь аюулгүйн нөхцөл хангах налууулалт, усны гүний ба аюултай бүсийн тэмдэглэгээ хийх ба аврах

зориулалтын төхөөрөмж, байгууламжийг төслөөр тооцож байгуулна.

- 6.4. Ил уурхайн гадаад овоолгууд үүсгэх
  - 6.4.1. Хожмын хэрэглээний нөхцөлийг харгалзан овоолгуудыг төрөлжүүлэх ба паспортжуулна.
  - 6.4.2. Барилга, замын материалд ашиглаж болох чулуулгийг тусгайлан хураах ба чанарт хяналт тавина.
  - 6.4.3. Кондицийн бус хүдрийн овоолгуудыг шинж чанараар нь төрөлжүүлж хураана.
  - 6.4.4. Хоосон чулуулгийн (хэрэглээний чанаргүй) овоолгыг тусгайлан хураана.
  - 6.4.5. Овоолгын хажууг MNS5917: 2008 стандартын дагуу налуулна.
  - 6.4.6. Овоолгын хажууд тэгш тавцан, эсрэг налуутай тавцан үүсгэж усанд идэгдэх эвдрэлээс сэргийлэх, усыг зайлуулах систем бүрдүүлнэ.
  - 6.4.7. Овоолгын дээд ба хажуугийн гадаргууг нөхөн сэргээж үндсэн чиг баримтлалтай уялдуулж засах, тэгшлэх ба хэлбэржүүлнэ.
  - 6.4.8. Өндөр овоолгын хажууд эвдрэлээс сэргийлэх зорилгоор бэхлэлт, хаалт, хамгаалалт, бөхжүүлэлтийг төслийн шийдлийн дагуу хэрэгжүүлнэ.
  - 6.4.9. Овоолгоос хортой бодис уусгасан усны нэвчилт, шүүрэлт үүсэхээс сэргийлж саармагжуулах (шохойжуулах гэх мэт) ажиллагааг төслийн дагуу хэрэгжүүлнэ.
  - 6.4.10. Овоолгоос гарч болох шүүрэлтийг шингээх суваг, саармагжуулах хураагуур зэрэг байгууламжийг шаардлагатай тохиолдолд байгуулна.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү бодлогын судалгааны зорилго, зорилтуудыг хангахын тулд дараах аргуудыг ашиглав.

- Баримт бичгийн агуулгын шинжилгээний аргаар хууль эрх зүйн баримтууд, өмнө хийгдсэн судалгааны тайлан, хэвлэгдсэн материалыг судлах,
- Уул уурхайн нөхөн сэргээлт, уурхайн хаалтын чиглэлээр явагдсан уулзалт, хурал, зөвлөгөөнүүдэд оролцон ажиглалт, ярилцлагын аргаар өнөөгийн байдал, хууль журмуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх,
- Ганцаарчилсан ярилцлагуудаар тодорхой сонирхогч тал, бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдийн үнэлгээ, дүгнэлт, байр суурь, туршлагыг судлах, зэрэг болно.

### • Баримт бичгийн судалгаа

Сэдвийн хүрээнд ашигт малтмал олборлох салбарт үйлчилж буй Монгол Улсын хууль эрхзүйн актууд болох “Ашигт малтмалын тухай хууль”, “Газрын тухай хууль”, “Газрын хэвлийн тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”, “Усны тухай хууль”, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”, “Газрын төлбөрийн тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”, Засгийн газрын 2006 оны 309-р тогтоолын дагуу хэрэгжүүлж буй “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах” хөтөлбөр, “Уурхайг түр болон бүрмөсөн хаах тухай журам” зэргийг судалсан.



- **Холбогдох хурал, зөвлөлгөөнд оролцох үед хийсэн ажиглалт, ярилцлага**

Мэдээлэл цуглуулах хээрийн судалгааны ажлын хүрээнд уул уурхайн нөхөн сэргээлтийн асуудлаар 2009 оны 9-р сард УМХГ Уул уурхайн хяналтын улсын албанаас Тэрэлжид зохион байгуулсан сургалт семинар, Багануурын уурхайг түшиглэсэн нөхөн сэргээлтийн ажлын үзүүлэх сургалт, 2009 оны 10-р сард АМГ-аас Чингис зочид буудалд зохион байгуулсан Уурхайн хаалтын зөвлөлдөх уулзалт зэрэгт оролцож төрийн болон салбарын мэргэжлийн байгууллагууд, уул уурхайн компаниудын уурхайн хаалтын чиглэлээрхи арга хэмжээ, бодлого, тулгамдсан асуудлуудтай танилцсан. Мөн ННФ-ын зардлаар 2009 оны 9-р сарын 7-11-ний өдрүүдэд Австрали улсын Перть хотод зохион байгуулагдсан “Уурхайн Хаалт-2009” олон улсын бага хуралд оролцож уурхайн хаалтын асуудлыг олон улсын хэмжээнд хэрхэн зохион байгуулж, зохицуулж байгаа туршлагыг судалж, шинэ санаануудтай танилцсан.

- **Ганцаарчилсан ярилцлага**

Судалгааны ажлын эхэнд болон эцэст судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох, боловсруулсан материалын талаар санал солилцох зорилгоор уул уурхайн асуудлаар бодлого тодорхойлогч, хэрэгжүүлэгч агентлагийн тухайн чиглэлээр ажиллаж буй албан хаагч, судлаач зэрэг сонирхогч талуудыг хамруулсан ярилцлага 12 удаа хийсэн.

Дээрх арга зүйн чиглэлүүдээр хийсэн судалгаа шинжилгээний ажлын гол үр дүнг бодлогын судалгааны тайлангийн үндсэн агуулга болох дараах бүлгүүдэд тусгав.

## НОМЗҮЙ

1. Andy B. Fourie, Mark Tibbett. Mine Closure 2009, Proceedings of the fourth international conference on mine closure (Australian Centre for Geomechanics), ISBN 978-0-9804185-9-0
2. Уул уурхайн салбарт мөрдөгдөж буй хууль, журмын эмхэтгэл. УМХЕГ-ын хэвлэл, 2009 он
3. Газрын нөхөн сэргээлт (Олон нийтэд зориулсан гарын авлага), АНУ-ын Азийн Сан. 2009 он
4. Очирбат П. Уул уурхайн үйлдвэрийн хаах үйл явц ба байгаль орчин. Инженерийн лавлах-5. Ил уурхайн технологи ном. 2-р хэвлэл. 15,11-р бүлэг, 548-560х УБ 2009.
5. Цэдэндорж С. Амарсайхан Ц. Уурхайн хаалтын чиг баримтлал. Уул уурхайн технологи, эдийн засаг, экологи геодези, газрын харилцаа. Эмхэтгэл 4-6х УБ 2009.
6. Гомбосүрэн Я. Байгаль хамгаалал уурхайн нөхөн сэргээлт. Инженерийн лавлах-5. Ил уурхайн технологи ном. 2-р хэвлэл. 16-р бүлэг, 561-600х. УБ 2009.